

МОНГОЛ УЛСЫН ЗГМ ШИЛДЭГ СОНИН

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

~ THE OFFICIAL GAZETTE ~

2017.01.13, БААСАН ~ №009 (555)

ҮНЭ: 600Т

ОНЦЛОХ

УЛС ТӨР

Ерөнхий сайд ҮАБЗ-ийн хөтөлбөрийн төслийг боловсруулахыг сайд нарт үүрэгдэв. **Хууль тогтоомжийг 2020 он** хүртэл боловсронгуй болгох тогтоолын төслийг УИХ баталлаа. **Хэнтий хаан уулыг Бурхан** халдун болгож өөрчлөх талаар санал солилцжээ. **Намууд Ерөнхийлөгчийн** сонгуулийн тухай хуулийн төслийн талаар хэлэлцлээ. **Үндсэн хуулийн 25 жилийн** ойг тохиолдуулан АИХ-ын депутатуудад хүндэтгэл үзүүлнэ.

ЭДИЙН ЗАСАГ

Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүдийг шинээр томиллоо. **Валютын дуудлага** худалдаагаар төв банк 2.5 сая ам.доллар банкуудад нийлүүлэв. **БНХАУ-ын импортоор авах** байгалийн хийн хэмжээ энэ онд 30 хувиар нэмэгдэнэ. **Монголын хөрөнгийн биржийн** индекс 847.14 нэгж болж 0.18 хувиар буурав. **Говь-Алтай-Баянхонгор** чиглэлийн 256 км авто замын барилгын ажил энэ хавар эхэлнэ.

НИЙГЭМ

Улсын хэмжээнд 68 сум зудын, 57 сум зудархуу байдалтай байна гэж ОБЕГ-аас мэдээлэв. **Өнгөрсөн онд Улаанбаатар** хөдөөнөөс 25160 иргэн шилжин иржээ. **Мянганы сорилын сангийн** санхүүжилтээр тархины судсан дотуурх мэс засал хийж байна. **ЮНЕСКО-ийн тусламжтайгаар** Монголын соёлын өвийг дэлхийд сурталчлах боломж бүрдлээ. **Сэлэнгэ аймгийнхан огтолсон** нэг модныхоо оронд 10-ыг тарих даалгавар өгчээ.

ДЭЛХИЙ

АНУ-ын Сенат Обамагийн эрүүл мэндийн хөтөлбөрийг цуцлах санал өгсөн байна. **Оросын ТУ-154 онгоцны** осолд алан хядлага ороогүй гэж шинжээчид дүгнэжээ. **Австралийн зэвсэгт хүчин анх** удаа Японд зэвсэг нийлүүлэхээр тохиролцлоо. **Хятадад 2016 онд 720 хүнийг** байгаль орчны хууль зөрчсөн хэрэгт баривчилжээ. **НҮБ-ын ЕНБ-ийн дарга асан** Пан Ги Муны дүүг АНУ-ын шүүх авлигад буруутгав.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

2017.01.13



-16° | -27°

ҮҮЛШИНЭ

ЦАГ АГААРЫН ДЭГЭРЭЖҮҮЙ МЭДЭЭЛИЙГ 8 ДУГААР НУУРГУУЖ УНИШВА УУ.



Бүх эрх хуулиар хамгаалагдана ©



Байгальд ээлтэй эл үйлдвэрлэлийг нэвтрүүлэхээр хөрөнгө оруулалтын платформоор дамжуулан 20 мянган ам.доллар босгохоор төлөвлөсөн ч сарын дараа 278 мянган ам.доллар цуглав. ▶3

ЗГМ: СЭДЭВ

Хамгийн зөв шийдэл нь сурагчдын автобус

51 сургуулийн 7626 сурагчдад 128 автобус үйлчилж байна

Г.Баярсайхан @bayarsaikhanZGM

Нойр ихтэйгээс болж ажлаасаа хохорчих гээд байдаг миний

хувьд ойрын хэдэн өдөр яс цагтаа ирээд сайхан л байна. Замын түгжрэл эрс багассан нь үүний ач л даа. Харин хөдөлгөөн яагаад сийрэг болов гээд харахаар ерөнхий боловсролын болон их, дээд сургуулийн амралттай холбогдож байна. Ялангуяа дунд сургуулиуд амрах нь хөдөлгөөний нягтралд ямар их нөлөөтэй болохыг нийслэлчүүд энэ хэд хоногт мэдэрлээ.

Уг нь замын хөдөлгөөний ачаалал хүүхдийн амралтаас

шалтгаалахгүйгээр байнга сийрэг байх боломж бий. Гаргалгаа нь сурагчдын автобус. Америкийн кинонд их гардаг даа, шар өнгийн тусгай автобусаар хүүхдүүд нь сургуульдаа ирж, очоод л. Чухам энэ үйлчилгээ түгжрэлийг бууруулах томоохон гарцын нэг гэдгийг улс орнууд аль эрт ойлгож, хэрэгжүүлсэн. Харин манайд бол дөнгөж эхлэлийн шатандаа явна.

▶5

ЗГМ: ИНФОГРАФИК



ЭДИЙН ЗАСАГ

Хөөс замхарч, хөрсөнд бууж буй үнэ

Орон сууцны бодит үнэ ойртлоо

Г.Байгал @baigalZGM

Бодит үнэ тогтоход ойртлоо. Орон сууцны үнийн хөөс хагарч, ханш хөрсөндөө бууж эхэллээ. Ганцхан жишээ тагъя. Өнгөрсөн сард орон сууцны үнийн индекс 1.009 нэгжид хүрчээ. Уг индексийг 2013 оны нэгдүгээр сард анх тооцсон. Чухам энэ үед индексийн утга 1000 нэгжийг зааж байв. Гурван жилийн өмнөхийг сөхөж, индексийн эхний утгыг онцолсон нь учиртай. Нэхэн санавал 2013 он бол орон сууцны зах зээлд эргэлт авчирсан онцгой жил

байсан юм. Олон улсад ипотека хэмээн нэрлэдэг орон сууцны хөнгөлөлттэй зээл Монгол Улсад хэрэгжиж эхэлсэн. Монголчууд анх удаа урт хугацаатай, найман хувийн хүүтэй орон сууцны зээл авсан үе. Ингэснээр орон сууцны эрэлт нэмэгдэж, борлуулалт эрчимжсэн.

Гэтэл эрэлтэд дөрөөлсөн барилгын компаниуд энэ үеэр үнээ эрээ, цээргүй нэмж орхисон юм. Үүнийг олон улсад “хөөс” хэмээн товчхон нэрлэнэ. Ханшийн хөөс тэлэх үед үнийн индекс 1250 нэгжид хүрч байсан түүх бий. Үнэ ч, индекс ч тэр оргилдоо тулж байв, энэ үед.

Гэвч Монголын эдийн засгийн өсөлт саарахын хэрээр хөөс хагарлаа.

▶11



Трамп хэвлэл, тагнуулынхныг шүүмжлэв

Сэм Флеминг, Кортни Вивер

Бууж өгөх маш дургүй Дональд Трамп Ерөнхийлөгчөөр сонгогдсоныхоо дараах анхны хэвлэлийн бага хурал дээр АНУ-ын тагнуулын албад түүнийг эрхэндээ оруулах баримт оросуудад бий гэсэн мэдээ тараасан хэмээн буруутгав. Тэрбээр уг үйлдлийг “Нацист Германд л ийм юм хийх байх” хэмээн зүйрлэжээ. Ил болгосон мэдээлэлд Москвагай түүний хувийн болон компанийн хэлхээ холбооны талаар нотолгоогүй боловч ноцтой зүйл яригдсаныг Трамп ихэд эгдүүцэн няцаасан юм. Түүний хэлснээр уг зүйл нь “өвчтэй хүмүүсийн зохиосон хуурамч мэдээ” гэнэ.

Трампа Нью-Йорк дахь төв байрандаа сэтгүүлчидтэй уулзахдаа, хэрвээ үүнийг АНУ-ын тагнуулын байгууллагаас тараасан бол тэдний хувьд “том хар толбо” болж үлдэнэ гээд “Иймэрхүү зүйлийг хэзээ ч бичиж болохгүй. Бүгдээрээ хуурамч мэдээлэл, зохиомол зүйл. Ийм юм байхгүй” хэмээн мэдэгдэв. Сонгогдсон Ерөнхийлөгч албан тушаалдаа орохоос 10 хүрэхгүй хоногийн өмнө Зэвсэгт хүчний ерөнхий командлагч болон тагнуулын албаны хооронд хэнэсээ зөрчил үүсч болзошгүй байгаа нь түүхэнд үзэгдээгүй явдал.

▶9

MSE ALL 847.14 0.18%	АЛТ 1199.60 0.71%	ЗЭС 5714 0.76%	10-ЧИНГИС БОНД 85.789 0.01%	5-ЧИНГИС БОНД 96.570 0.03%	АМ.ДОЛЛАР 2497.04	ЮАНЬ 361.37	РУБЛЬ 42.01
-----------------------------------	--------------------------------	-----------------------------	--	---	-----------------------------	-----------------------	-----------------------

Улс төр

Үндсэн хуулийн өдөрт

Эрийн цээнд хүрсэн “эцэг” хуулийг өөрчилж мэдэх нь

Үндсэн хуулийн зарим заалт гүйцэтгэх эрх мэдлийг тогтворгүй болгодог

Б.Гандолгор
@gandolgorZGM

Монголчууд шинэ Үндсэн хуулиа баталсны 25 жилийн ой өнөөдөр тохиож байна. Тус хууль нь засаглалын болон хүний эрхийг хангах үүргээ маш сайн гүйцэтгэж ирсэн гэж судлаачид дүгнэдэг. Өнгөрсөн жилээс эхлэн Үндсэн хуульд өөрчлөлт оруулах талаар эрх баригчид хөндөх болсон. УИХ-ын зарим гишүүний хэлснээр хуулийг эхлээд мөрдөж хэвших хэрэгтэй. Харин олон жил мөрдөөд ирэхээр заншил болдог хэмээж байсан. Жишээлбэл, Франц Иргэний хуулиа 1806 онд баталжээ. Үүнээс хойш өөрчлөлт оруулалгүйгээр өдий хүртэл мөрдөж ирсэн тухай ч зарим гишүүн дурдаж байлаа. Гэтэл манай улс 1992 онд анх Үндсэн хуулиа баталж, үүнээс найман жилийн дараа 2000 онд өөрчлөлт оруулсан байна. Тухайн үед долоон заалтыг өөрчилсөн нь өдгөө буруудсан гэсэн шүүмжлэлд өртөөд байгаа. Шинээр оруулсан долоон заалт гишүүдэд эрх мэдэл шунах боломжийг олгож, сайдын албыг давхар хаших нөхцөлийг бүрдүүлсэн. Ерөнхий сайдын эрх мэдлийг хязгаарлаж, УИХ-д хэтэрхий эрх мэдэл олгосон заалт болсон тухай зарим судлаач шүүмжиллээ.



С.Батсайхан / ЗГМ ©

Одоогоор Үндсэн хуулийг өөрчлөх хоёр ч Ажлын хэсэг байгуулаад байна. Тодруулбал, УИХ-ын гишүүн Д.Лүндээ-жанцангаар ахлуулсан Ажлын хэсгийг МАН-ын бүлэг байгуулсан. Мөн Ерөнхий сайдын захирамжийн дагуу Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, эсэхийг судлах, санал, дүгнэлт боловсруулах Ажлын хэсэг байгуулаад байна.

Их, дээд сургуулийн багш, эрдэмтдээс бүрдсэн Ажлын хэсэг пүрэв гарагт Үндсэн хуулийн өөрчлөлтийн талаар хэлэлцүүлэг хийсэн юм. Тус хэлэлцүүлгийн үеэр МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш О.Мөнхсайхан “Ардчилсан нийгмийн гол баталгаа бол

Засгийн газрыг амархан огцруулах боломжийг 2000 оны өөрчлөлт бүрдүүлсэн

Үндсэн хуулиар хүний эрхийг хамгаалахад оршдог. Миний хувьд зарим нэг зүйлийг өөрчлөх шаардлага бий гэж үздэг. Ерөнхий сайд танхимын гишүүдэд бүрдүүлэхийн тулд Ерөнхийлөгчөөр зөвшөөрүүлдэг. Үүнийг өөрчлөх шаардлагатай гэсэн саналтай байгаа. Түүнчлэн УИХ-ын

гишүүн, сайдын албыг давхар хашдаг болгосон нь сөрөг заалт. Ийм байдлаас болоод гүйцэтгэх эрх мэдэл тогтворгүй байна.

Нөгөөтэйгүүр, Засгийн газрыг маш амархан огцруулах боломж бүрдүүлсэн нь 2000 онд оруулсан өөрчлөлтийн сул тал. Би 20 улсын хуулийг харьцуулж судалсан. 18 улсынх нь танхимын гишүүдэд Ерөнхий сайд нь өөрөө сонгодог юм билээ.

Манай улсын Ерөнхий сайдын бүрэн эрхийн хугацаа арай бага байна. Гэтэл Германын 8.1 жил, Английнх 5.6 жил, Ирландынх зургаан жил байх жишээтэй. Иймд үүн дээр нэмэлт, өөрчлөлт оруулахтай санал нэгдэж байгаа. Гэхдээ

Үндсэн хуулийн хүний эрхийн хэсэг заримдаа мөрдөгддөггүй. Хотын удирдлагууд иргэдийн газрыг булаах үзэгдэл гардаг” гэлээ.

Эрдэмтэн, судлаачдаас бүрдсэн Ажлын хэсгийнхэн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн талаар хэдэн удаа цуврал уулзалт хэлэлцүүлэг хийхээр төлөвлөжээ. Уг Ажлын хэсгийнхний хоёр дахь удаагийн уулзалт, хэлэлцүүлэг гуравдугаар сард болох юм байна. Үүний дараа хөдөө орон нутгаар явж мөн хэлэлцүүлэг өрнүүлнэ. Ингээд нэгдсэн санал дүгнэлт гаргасны дараа УИХ-ын гишүүдээс бүрдсэн Ажлын хэсгийнхэнтэй уулзана гэдгээ дуулгаж байв. [ЗГМ]

БАЙР СУУРЬ

А.Эрдэнэцогт: Парламентын засаглалаа бэхжүүлэх ёстой

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн профессор А.Эрдэнэцогттой уулзаж, Үндсэн хуульд өөрчлөлт оруулах, эсэх талаар ямар байр суурьтай байгааг нь тодрууллаа.

–Үндсэн хуульд өөрчлөлт оруулах шаардлага бий юу?

–Аливаа улс орон Үндсэн хуульдаа 15-20 жилд тодорхой өөрчлөлт оруулдаг гэсэн судалгаа бий. Манай улс 1992 онд Үндсэн хуулиа баталснаас хойш нийгэм, эдийн засгийн байдал маш их өөрчлөлт гарлаа. Хүмүүсийн сэтгэлгээ, зан төлөв ч өөрчлөгдөөд байна. Мөн төрийн байгууллагууд үйл ажиллагааны явцаа асар их туршлага хуримтлуулав.

Нөгөөтэйгүүр тодорхой асуудал хуримтлагдаад байна. Өнгөрсөн хугацаанд Үндсэн хууль үүргээ маш сайн гүйцэтгэж ирсэн. Парламентын засаглалыг хөгжүүлэх явцад өнөөдрийг хүртэл шийдвэрлэж чадаагүй зүйл бий. Судлаачид, эрдэмтэд өөр өөрийн өнцгөөс байр сууриа илэрхийлдэг. Зарим нь Үндсэн хуулиа мөрдөөгүйгээс өнөөдрийн засаглалын хямралд хүрч, эрх мэдлийн давхцал үүссэн гэх нь ч байна.

–Хариуцлагын тогтолцоогүй болсон гэж зарим судлаач шүүмжилдэг. Энэ талаар та юу хэлэх вэ?

–Төрийн дээд эрх мэдлийн байгууллагын хариуцлага суларсан гэж хоёр талцсан байдалтай байгаа. Тэгэхээр судлаачид Үндсэн хуульд тодорхой өөрчлөлт оруулах хэрэгтэй юм байна. Ингэхгүй бол Ерөнхийлөгч, УИХ, Засгийн газар гэсэн институцийн уялдаа холбоо алга. Хариуцлага нэгэн рүүгээ түлхдэг болсон. Тиймээс Үндсэн хуульд өөрчлөлт оруулах ёстой гэдэгт санал нэгдсэн гэж ойлгож байгаа.

Би судлаачийн хувьд төрийн тогтолцоо тэр дундаа парла-

ментын засгийг гүнзгийрүүлэхэд чиглэсэн өөрчлөлт оруулах ёстой гэж үзэж байна. 1992 онд манай улс парламентын засаглалыг сонгосон. Үүнийгээ л бэхжүүлэх ёстой. Гүйцэтгэх эрх мэдлийн чиг үүрэг тарсан байдалтай байна. УИХ зарим чиг үүргийг Ерөнхийлөгчид олгосон. Хэн нь илүү эрхтэй вэ гэдэг уралдаан болоод байдаг. Энэ эрх мэдлийн хуваарилалтыг тодорхой болгох ёстой. Парламентын засаглалтай оронд Ерөнхий сайд давуу эрх мэдэл эдэлдэг. Гэвч манай парламентын засаглалыг сонгосон хэрнээ Ерөнхий сайдынхаа эрх мэдлийн талаар Үндсэн хуульд гүйцэт суулгаж өгч чадаагүй.

Үндсэн хуульд төрийн эрх барих дээд байгууллага нь УИХ байна гэж заасан. Тиймээс шүүх болон гүйцэтгэх эрх мэдлийн дээр УИХ суухаад байна. Гэтэл УИХ бол хууль тогтоох байгууллага учраас эрх мэдэл хуваарилах зарчимтайгаа таарахгүй байгаа. Энэ гурав харилцан бие биэндээ хяналт тавих ёстой гэсэн сонгодог онол бий.

–Дордуулсан долоон өөрчлөлтийг хасах хэрэгтэй гэж үзээд байгаа. Үүнтэй та санал нийлэх үү?

–Бүгд муу байгаагүй. Зарим заалтынх нь хэмжээ хязгаарыг хэтрүүлсэн. УИХ-ын гишүүн, Засгийн газрын гишүүн байж болдог заалт оруулсан нь том алдаа. Эрх мэдлийг гүйцэт хуваарилаагүй байж ийм өөрчлөлт оруулсан нь өнгөрсөн жилүүдэд байдлыг улам дордуулсан. Парламентын засаглалтай оронд төсвийн бүрэн эрх Ерөнхий сайдын мэдэлд байдаг. Гэтэл манайх УИХ-аар оруулаад, тойрог руу хөрөнгө татаад 180 градус эргүүлдэг. Ийм байдлаас болоод Үндсэн хууль үүргээ гүйцэтгэж чадахгүй болох нөхцөл бүрэлдсэн. Тэгэхээр бүх нийтээрээ сайн хэлэлцэж оновчтой өөрчлөлт оруулах ёстой. [ЗГМ]

ТӨСӨЛ

Сонгуулийн зардал нэмэгдэж байгаад анхаарах хэрэгтэй гэв



С.Батсайхан / ЗГМ ©

Б.Тогтох
ЗГМ

УИХ дахь Ардчилсан намын бүлгээс улс төрийн хүчнүүдийн дунд Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн талаар хэлэлцүүлэг зохион байгуулав. УИХ-ын гишүүн Н.Энхболдын өргөн мэдүүлсэн уг төслийг эрх баригчдад ээлтэй төсөл хэмээн цөөнхийн бүлэг хардаж, парламентад суудалгүй намуудын төлөөллөөр хэлэлцүүлэх шийдвэр гаргасан нь энэ.

Хэлэлцүүлгийн эхэнд УИХ-ын гишүүн Л.Болд хуулийн төслийн талаар товч мэдээлэл өгсөн юм. Тэрбээр “104 зүйл, заалттай уг хуулийн төсөлд Үндсэн хууль тайлбарласан заалт бий. Ингэснээр Үндсэн хуулийн цэц дээр маргаан үүсэх эрсдэлтэй. Нөгөөтэйгүүр, УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны хурал дээр 64 зарчмын зөрүүтэй санал гарсан. Эрх баригчид яаралтай батлах нэрийдлээр өөрсдөдөө ашигтай хувилбараар батлах гэж байна” хэмээн байр сууриа илэрхийлэв.

Ардчилсан намын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч Л.Эрхэмбаяр “Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийг манай нам Гүйцэтгэх зөвлөл болон Үндэсний зөвлөлдөх хороогоор ч хэлэлцээгүй байгаа. Гэхдээ энэ

хуулийн төсөлд бид нэг зүйлийг онцгой анхаарах хэрэгтэй байна. Сонгуулийн ерөнхий хороо бүх шатны сонгуулийн хороодын ажилтнуудыг шууд томилохоор заасан байна. Сонгуулийн дараа төрийн албанд томилсон өөрсдийн хүмүүсээ оруулж, зохион байгуулаа гэсэн үг. Гэтэл сонгуулийг будлиантуулсан хүмүүсийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон түүнийг 21-26 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэж заажээ. Энэ бол хэтэрхий бага мөнгө. Тиймээс торгуулийн хэмжээг нэмэх шаардлагатай.

Сонгуулийн зардлын хэмжээ өсөж, 14-15 тэрбум төгрөг хүрчээ

Сонгогчийн нэрсийн жагсаалт гэсэн бүлэгт “Сонгогчийн сонгуулийн зөвхөн нэг хэсгийн хороонд бүртгэнэ” гэж заасан байна. Үүнийг хянах тогтолцоо хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, сонгуульд өрсөлдөгчид тусгай программаар тухайн сонгогчийг өөр газарт давхар бүртгэсэн үү гэдгийг шалгах бололцоог хангах нь чухал. Энэ бол “царааны нүү-

дэл”-ээс хамгаална гэсэн үг” гэлээ.

Харин МҮАН-ын дарга Б.Цогтгэрэл “Ерөнхийлөгчийн статусыг илүү тодорхой, нэр хүндтэй байлгах үүднээс сонгуулийг бие даасан хуулиар зохицуулах нь зөв. Хуулийн төслийг боловсруулах даа Үндсэн хуулийн суурь зүйл, заалтыг эшлэл болгосон байсан. Тиймээс аль нэг улс төрийн хүчинд зориулсан хуулийн төсөл болсон гэж хэлэхэд хэцүү. Насны хязгаар, эх орондоо байх хязгаар болон дэвшүүлэх субъектийн хувьд ч өмнөх хуулиудад байсан зүйл, заалт” хэмээв.

Хэлэлцүүлэг оролцсон төлөөлөл сонгуулийн зардалд анхаарах ёстойг санууллаа. Тодруулбал, анхны Ерөнхийлөгчийн сонгуулийг 40 сая төгрөгөөр зохион байгуулж байсан бол сонгуулийн зардлын хэмжээ өсөж, 14-15 тэрбум төгрөгт хүрсэн гэдгийг дуулгав.

Хэлэлцүүлгийн үеэр парламентад суудалгүй улс төрийн хүчнүүдийн төлөөлөл УИХ дахь цөөнхийн бүлэг болох Ардчилсан намд шүүмжлэлтэй хандсан юм. Тухайлбал, Эрх чөлөөг хэрэгжүүлэгч намын дарга Ш.Төмөрсүх УИХ-д сөрөг хүчний үүрэг гүйцэтгэж байгаа нам парламентад суудалгүй намуудыг гуйдаг тогтолцоогоо халах хэрэгтэйг сануулсан юм. [ЗГМ]

ТОВЧХОН

» ТОМИЛГОО

УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын ерөнхий аудитор А.Зангадыг чөлөөлж, түүний оронд Д.Хүрэлбаатарыг томилжээ. Д.Хүрэлбаатар нь 2016 оноос Ерөнхий сайд болон Барилга, хот байгуулалтын сайдын орон тооны бус зөвлөхөөр ажиллаж байжээ. Үүнээс гадна Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн Д.Дэлгэрцогтыг чөлөөлж, түүний оронд Цагдаагийн ерөнхий газрын дарга Ө.Энхтөрийг томиллоо.

Монголбанкны хяналтын зөвлөлийн даргаар МУИС-ийн Олон улсын харилцаа, нийгмийн удирдлагын сургуулийн ахлах багш Д.Даваасамбууг томиллоо. Харин зөвлөлийн гишүүдэд МҮХАУТ-ын Удирдах зөвлөлийн дарга Б.Лхагважав, “Их Амар” группийн ерөнхийлөгч М.Энх-Амгалан, Удирдлагын академийн тэнхмийн эрхлэгч Л.Ариунаа, “Эрхэм хуульч” нөхөрлөлийн гүйцэтгэх захирал Б.Цэрэнбалтав нарыг томиллов. Үүнээс гадна Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэнгийн тэргүүн Л.Дондог, Монголын мэргэшсэн нягтлан бодох бүртгэлийн институтын гүйцэтгэх захирал Ч.Чимидсүрэн нар уг зөвлөлийн гишүүнээр сонгогдов.

» ЗАСГИЙН ГАЗАР

Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат Үндэсний аюулгүй байдлын өргөтгөсөн хуралдааны зөвлөмжид заасан хууль, шийдвэр хөтөлбөрийн төслийг яаралтай боловсруулахыг холбогдох сайд нарт үүрэг болгожээ.

» ТОО

800

Шашны байгууллага. 1991 оны үед Монгол Улсад 130 гаруй шашны байгууллага үйл ажиллагаа явуулж байсан бол өнөөдрийн байдлаар зөвшөөрөлтөй 800 орчим, зөвшөөрөлгүй 200-гаад байна. гэсэн судалгаа гарчээ. Энэ нь Төр, сүм, хийдийн харилцааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт хийх нэг гол үзүүлэлт гэж үзэж байгаа аж.

» УУЛЗАЛТ

УИХ-ын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Ц.Гарамжав Шинжлэх ухааны академи, их, дээд сургуулиудын багш, эрдэмтэн, судлаачидтай уулзаж, Хэнтий хаан уулын нэрийг Бурхан халдун уул гэж өөрчлөх тухай УИХ-ын тогтоолын төслийн талаар санал солилцжээ. Уулзалтын үеэр судлаачид тогтоолын төсөлд газрын зурагт албан ёсоор тэмдэглүүлэх солбилцлыг тодорхой тусган нэрийг нь өөрчлөх ёстой гэсэн саналыг гаргав.

» ПАРЛАМЕНТ

УИХ-аас Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэл батлах тухай тогтоолын төслийг батлав. Үүнээс гадна УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, Нийтийн сонсгол зохион байгуулах тухай журам баталлаа.

ТОДРУУЛГА & ЗАЛРУУЛГА

Уншигч та манай сонины мэдээ, нийтлэл, сурвалжлагатай холбоотой тодруулж, залруулах шаардлагатай санал, хүсэлт байвал

» OPED@ZASAG.CO

Утас: 99901526 хаягаар бидэнтэй холбогдоно уу.

Нийтлэлчийн булан

Ноёлогч хуванцрын ногоон өрсөлдөгчид

Шар будаагаар хийсэн халбаганы жилийн борлуулалт 1.5 сая ширхэг давжээ

З.Цэлмэг
@tselmegZGM

Антропоцены эрин үеийн томоохон төлөөлөгчдийн нэг хуванцрыг хэрэглэнээс халах оролдлогууд амжилттай өрнөж байна. Хүн төрөлхтний жилд үйлдвэрлэдэг хуванцрын хаягдал 110 сая тонноор хэмжигдэх болжээ. Үүний багахан хэсэг нь дахин боловсруулалтад орж, хэрэглээнд нэвтэрдэг. Харин үлдсэн нь хүний үйл ажиллагааны улмаас үүсээд буй Антропоцены хэмээх геологийн үзэгдэлд жин дардаг.

Үүндээ хуванцарт хүлэгдсэн бидний ахуй байгаль эхээ гэх сэтгэлийг минь дарлаж буй нь нууц биш. Тиймээс ч өдөр тутмын амьдралд чимээгүй хэрнээ “хүндтэй” байр эзэлсэн хуванцрыг дэмжигчид байгальд задрах хугацааг нь богиносгоход анхаарч буй. Ёс зүйтэй эл чармайлтын үр дүнг чамлах аргагүй. Гэхдээ ноёлогч хуванцрын ногоон өрсөлдөгчийн тоо нэмэгдэж байгаа нь чухам үнэн ажээ.

АМТАТ ШАР

Нэг удаагийн хуванцар халбага, сэрээг орлох ногоон шийдэл өнгөрсөн оны шилдэг инновациудын нэгээр тодорчээ.

Энэтхэг улсад жилд хаягддаг нэг удаагийн хуванцар халбага, сэрээний тоо 120 тэрбумаар хэмжигддэг байна. Аварга тоо байгаа биз. Тиймээс үүнийг багасгах зорилгоор тус улсын “Bakeys” компани нэг удаа хэрэглээд, дараа нь идчихдэг халбага үйлдвэрлэж, зах зээлд гаргасан нь амжилт олжээ. Эл шинэ шийдлээ “Хэрэглэ, дараа нь ид” хэмээх уриа үгээр тодотгосон байна. Бүтээгдэхүүний гол түүхий эд нь шар будаа. Үүн дээрээ багахан



С.Батсайхан/ЗГМ

цагаан будаа, буудай нэмж, давс, сахар, синнамоноор амталснаар зугаатай, байгальд ээлтэй халбага бэлэн болдог байна.

“Bakeys” компанийг үүсгэн байгуулагч Нараяна Пийсапати Олон улсын газар тариалангийн судалгааны хүрээлэнд насаараа ажилласан нэгэн. Тиймээс ч иддэг халбаганы түүхий эд бэлтгэл, үйлдвэрлэл, хэрэглээг байгальд ээлтэй байх шийдлийг олон жил боловсруулсан байна.

Шар будаа нь ургах явцад цагаан будаанаас 60 дахин бага ус зарцуулдаг. Бас тариалахад арчилгаа багатайн дээр тэжээллэг чанараараа буудай, эрдэнэ шишээс илүү юм байна. Харин үйлдвэрлэлийн явцад хуванцар халбагатай харьцуулахад эрчим хүчний хэмнэлт 100 дахин их. Өөрөөр хэлбэл, нэг ширхэг хуванцар халбага үйлдвэрлэхэд зарцуулах эрчим хүчээр ийм “шидтэй” 100 халбага үйлдвэрлэдэг гэсэн үг. Тэгээд хаягдалгүй. Хаялаа гэхэд 4-5 өдрийн дараа бүрэн задарна.

Байгальд хурдан шингэдэг болгохын тулд халбаганд ямар ч тогтворжуулагч, тос хийдэггүй юм байна. Халуун цайнд хийсэн сахар уустал нь

хутгаж, халуун шөл халбагадах нэг удаагийн хэрэгсэл ийнхүү бүтдэг аж. Хэрэглэсэн халбагаа идэхэд зугаатай, бас хаясан ч хор болоод хөрсөнд шингэх вий гэдэгт айх шаардлагагүй. Ингэж орчин үеийн хэрэглэгчийн сэтгэл ханамжид хүрч чадсан учраас оны онцлох ногоон бизнесээр шалгарчээ.

Нараяна Пийсапати 2016 оны гуравдугаар сард энэхүү гарааны бизнесээ эхлүүлжээ. “Kickstarter” платформоор дамжуулан 20 мянган ам.доллар босгохоор төлөвлөсөн ч сарын дараа 278 мянган ам.долларын хөрөнгө оруулалт цугласан гэдэг. Энэ хөрөнгөөр үйлдвэрээ өдөрт 800 мянган халбага үйлдвэрлэх хүчин чадалтай болгож өргөжүүлсэн байна. Цаашид бүтээгдэхүүний найрлагыг сайжруулж, цавуулаггүй болгохын зэрэгцээ сэрээ, хутга, савх зэргээр төрөлжүүлэх хангалттай боломж байгааг Нараяна Пийсапати олж харжээ. Мэдээж үйлдвэрлэлийн хэмжээг өсгөх замаар бүтээгдэхүүнийхээ үнийг хямдруулж, гол өрсөлдөгч болох хямд үнэтэй хуванцар халбага, сэрээг зах зээлээс шахахаар

ажиллаж байгаа юм.

Яг ийм бүтээгдэхүүний хувилбар манай хөрсөнд хэрхэн буухыг хэлж мэдэхгүй. Гэхдээ, ядаж л зайрмагны үйлдвэрлэлд нэвтрүүлэх гарц байгаа эсэхийг тандахаар эрэлд гарлаа. Зайрмагны модон иш, хуванцар халбагыг аарц зэрэг түүхий эдээр босгох боломжтойг асуухаар нэгэн үндэсний үйлдвэрлэгчтэй холбогдсон юм. Манай зайрмагны зах зээл 30-40 тэрбум төгрөгт эргэлддэг гэх албан бус мэдээ бий аж. Үүний 60 орчим хувийг үндэсний үйлдвэрлэгчид эзэлдэг. “Хэдийгээр технологийг нь нэвтрүүлж болох ч түүхий эдээ хямд татах боломжгүй болов уу. 600 төгрөгөөр борлуулдаг зайрмагны хувьд иш нь нэг төгрөгийн л өртөгтэй шүү дээ” хэмээн нэрээ нууцлахыг хүссэн эх сурвалж маань тайлбарлав.

СҮҮНИЙ УУРАГ

Хуванцар хаягдлын нэлээдгүй хэсгийг хүнсний баглаа, боодлын хаягдал эзэлдэг гэх статистик бий. Ийм төрлийн хуванцрыг ихэвчлэн газрын тосны гаралтай түүхий эдээр хийдэг. Тиймээс дахин ашиглах

боломжгүй, шууд хаягддаг. Хөрсөнд задрах гэж бүтэн 100 жил “аялдаг”.

Нөгөөтэйгүүр, эл шийдэл хүнсийг эрүүл чигээр хадгалах онцтой сонголт биш аж. Орчин өөрчлөгдөх бүрт хүний эрүүл мэндэд хор учруулах нэгдлүүд ялгаруулдаг нь олон судалгаагаар тодорхой болжээ. Тиймээс уг асуудал Америкийн эрдэмтэд завгүй ажиллаж буйн бас нэг шалтгаан болсон гэдэг. Тоолж барамгүй их туршилт, судалгааны үр дүнд дээрх асуудлын шийдэл нь сүүний

» Нэг удаагийн хуванцар халбага, сэрээг орлох ногоон шийдэл өнгөрсөн оны шилдэг инновациудын нэгээр тодров.

» Орчин үеийн хэрэглэгчийн сэтгэл ханамжид хүрч чадсан учраас оны онцлох ногоон бизнесээр шалгарчээ.

уураг болохыг илрүүлсэн байна. Сүүний уурагнаас гаргаж авсан хальсны чанар ул болсон хуучин шийдлээс 500 дахин их. Бүр тодорхой хэлбэл, хүнс исэлдэж муудах гол нөхцөл болдог агаарыг огт нэвтрүүлдэггүй байна. Сүүний уургаар хийсэн баглаа усанд уусахдаа хэдий удаан ч бүрэн задардаг.

Тэр чигтээ уурагнаас бүтэж буй уг баглааг цаашид амин дэм, хүний биед ашигтай төрөл бүрийн бичил биет, хүнснээс гаргаж авсан биологийн идэвхт бүтээгдэхүүнээр баяжуулах боломжтой гэнэ. Амт оруулаад идэж ч болох аж. Мэдээж иддэг баглаа боодлын эрүүл ахуйд илүүтэй анхаарах шаардлагатайг мэргэжилтнүүд зөвлөдөг.

ЖИЖИГ ТОГЛОГЧИД

Хаягдал хуванцрыг иддэг хүнсээр орлуулах технологи шинэсэн трэнд биш. Гэхдээ өнгөрсөн оны хувьд томоохон бизнес эрхлэгчид ч уг технологийг нэвтрүүлэхэд багагүй чармайлт гаргажээ. Тухайлбал, олон улсын түргэн хоолны сүлжээ болох KFC-ийн Энэтхэг дэх франчайзингийг эзэмшдэг компани хэд хэдэн салбартаа иддэг аяга туршиж үзэв.

Мөн 2015 онд Британи дахь салбарууд нь ч иддэг аяганд кофегоо савлан борлуулж байсан түүх бий. Тэрчлэн Нью-Йоркийн нэгэн түргэн хоолны сүлжээ пиццагаа иддэг хайрцагт савлаж зарсан нь хүмүүст янз бүрийн сэтгэгдэл төрүүлжээ. Далайн амьтдыг сайн дураар хамгаалдаг хэсэг залуус нийлж шар айрагны бэхлэггэ амьтан идсэн ч хор хөнөөл учруулахгүй найрлагатай болгосон гээд ногоон өрсөлдөгчийн тоо нэмэгдэж буйг илтгэх жишээ олон.

Гэхдээ л энэ бүх оролдлого хэрэглэгч, үйлчлүүлэгчид ямар хариу үйлдэл үзүүлэх нь чухал учраас нийтийн хэрэглээ харахан болж амжаагүй л байна. Түүнээс гадна тараг, цэвэр ус, цөцгий, жимсний шүүс гээд шингэн хүнсний савлагааг ч иддэг хүнсээр орлуулах туршилтууд олон улсад ид өрнөж байна. [ЗГМ]

С.ЦОГТБЯАР ЗУРЖ БАЙНА



Судлаачийн үг

Монголын олон нийт рүү чиглүүлэн тэрхүү сэжиглэл, болгоомжлолыг багасгах явдал нь бидний цаашид, удаан хугацаанд хэрэгжүүлэх гадаад харилцааны ажлын чухал үүрэг болох ёстой.



BBM©

иржээ.

Япончуудын хийж болж байгаа зүйлийг хятадууд бид яагаад хийж болохгүй гэж. Үүнд бидэнд онцгой давуу тал хараахан бүрэн дүүрэн бүрэлдээгүй байна. Хятад, Монгол хоёр нь өргөн хүрээнд соёлын арга хэмжээ хэрэгжүүлж болох талбар бол манай улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орон байж болно. Өвөр Монголоор жишээ болгож, хил дамнан оршин сууж буй нэг үндэстэн, монгол хэлээр хоорондоо ойлголцдог, зан заншил адил зэрэг нь хоёр талын энэ чиглэлийн харилцааг явуулахад маш хялбар бөгөөд ашигтай нөхцлийг бүрдүүлж байна. Хоёр тал монгол үндэстний морин хуур, уртын дуу, бөх, нум сум зэрэг олон талаар харилцаж, харилцаа, хамтын ажиллагаа, найрсаг дотно байдлаа бэхжүүлэх боломжтой. Хятад, Монгол хоёр улс 2005 онд уртын дууг ЮНЕСКО-ийн

кабелийн телевиз нэвтрүүлэг цацсанаас хойш Хятадын ТВ-ийн нэвтрүүлэг гарах болж, Хятадын төв телевизийн сувгуудаас гадна мөн Бээжин, Өвөр монгол, Шанхай, Шинжаан зэрэг хорь гаруй суваг Монголд гарах болж, үзэгчдийн эдийн засаг, соёл, биеийн тамир, боловсрол, өдөр тутмын амьдралд маш их нөлөө үзүүлж байна. Ингэснээр Монголын ард түмэн Хятадыг тодорхой ойлгох, мэдэх, Хятадын гүйцэтгэх үүргийг ойлгоход идэвхтэй хувь нэмэр оруулж байна. Иймээс энэ чиглэлээр сайн ажиллаж, улмаар монгол хүний хэрэгцээ шаардлагад нийцэхүйц хөтөлбөрөөр баяжуулах хэрэгтэй.

Хоёр орны соёлын харилцаанаас харахад, Күнзийн институт нээгдсэн болон 1998 онд хоёр улсын Засгийн газар хооронд гарын үсэг зурсан “Боловсролын зэргийг харилцан хүлээн зөвшөөрөх тухай хэлэлцээр” болон 2000 онд хоёр тал гарын үсэг зурсан

Монгол-Хятадын харилцаан дахь “Соёлын зөөлөн хүч” - 2

Г.Гомбо
Доктор (Ph.D)

Хятадын Төрийн Зөвлөлийн дэргэдэх Хөгжлийн судалгааны төвийн “Евразийн нийгмийн хөгжлийн судалгаа” сэтгүүл 2011 оны нэгэн дугаартаа дээрхи гарчгаар сэтгүүлч асан, одоо судлаач болсон эрхмийн бичсэнийг уншигчдын хүртээл болгосон. Одоо хоёр дахь хэсгийг хөрвүүлэн хүргэе.

Гурав. “Соёлын зөөлөн хүч”-ийг ашиглан манай улсаас сэрэмжлэх сэтгэлгээг бууруулах Илэн далангүйгээр өгүүлэхэд Хятад-Монголын харилцааны хамгийн том асуудал нь хоёр талын харилцан итгэлцэл дутмаг байгаа явдал юм. Хятадын онцгөөс харж өгүүлбэл зарим нэг хүмүүс Монголын тусгаар тогтнолыг янз бүрээр тайлбарладаг, бүр зарим нь Хятадын ар хударгаар гурван

Монголыг нэгтгэх гэж байна гэж харддаг.

Монголчуудын хувьд түүхэн шалтгаанаас улбаатайгаар цөөнгүй монгол хүн, түүний дотор засгийн эрх баригч зарим хүн Хятадаас сэрэмжилж байдаг ба Хятад нь эрт орой хэзээ боловч Монголыг эргүүлэн нэгтгэх гэсэн бодолтой байдаг хэмээн санаа зовнидог. Ердийн монгол хүмүүсийн тухайд Хятадад цагаанаар атаархах, атаархаж хорсох, басамжилж доромжлох, айж сэртхийх, харилцаж чаддаг ч бас өшиж хорсдог байдал оршоор байна. Хэт ойртохгүй, хэт холдохгүй, угтаж авна, харин элгэмсгээр ойртохгүй, хамтран ажиллана, гэхдээ дагахгүй, найрсаг байна, гэхдээ сэргийлнэ гэдэг нь бараг л Монголын хувьд Хятадын талаарх бодлого, стратеги нь болоод байна.

Хятад, Орос гэх хоёр том хөршийн дунд оршдог, геополитикийн үүднээс хоёр их хөрштэйгөө сайн харилцаатай байх ёстой гэж монголчууд үздэг. Зөвхөн ийм л янзаар Монголд ашигтай байж чадна. Гэвч үүний зэрэгцээ Хятад, Орос хоёр улсын аль нэг талын дарамт шахалтад орохгүйн үүднээс гуравдагч хөршийг эрэлхийлэн, аюулгүй байдлын баталгаагаа олохын зэрэгцээ олон улсын тавцан дахь байр сууриа бэхжүүлнэ, мөн их хэмжээний тусламж дэмжлэг олно хэмээн монголчууд үздэг.

Хятадтай тогтоосон тэдний харилцаа бол эдийн засгийн ашиг сонирхол дээр суурилсан бол улсын аюулгүй байдал, тусгаар тогтнолтой холбоотой асуудлын тухайд АНУ зэрэг барууны улсуудыг түшихэд чиглэгджээ. Гуравдагч хөрш хэмээх ойлголт нь бодлогын бичиг баримтаас урган гарсан юм. Энэхүү үзэл баримтлал нь 1994 онд Монгол Улсын Их Хурлаар хэлэлцэж баталсан тулгуур шинжтэй эрх зүйн бичиг баримт болох Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалууд юм. Тэргүүн хэсэгт нь Орос, Хятад нь Монголын гадаад бодлогын тэргүүлэх чиглэл гэсэн бол дараагийн заалтад нь “Эдийн засгийн салбарт, улсын стратегийн шинжтэй нөөцийг нэг улс болон хэд хэдэн улс дангаар эзэмшихийг хязгаарлаж, Монгол Улс бусад улсын түүхий эдийн хараат болохоос сэргийлнэ” гэжээ. Монголын хоёр их хөрш Хятад болон Орос бол түүний стратегийн нөөц баялгийн салбарт урьдчилан сэргийлэх чухал цэг болох нь маш тодорхой байна.

Нэн ялангуяа Монголын олон нийт рүү чиглүүлэн тэрхүү сэжиглэл, болгоомжлолыг багасгах явдал нь бидний цаашид, удаан хугацаанд хэрэгжүүлэх гадаад харилцааны ажлын чухал үүрэг болох ёстой. Монгол хүмүүсийн дунд оршоор байгаа хятадын эсрэг дээрхи үзэл бодлоос харахад тэгэхээс өөр арга алга. Энэ бол хоёр улсын түүхэн

баялаг харилцаа болон одоогийн харилцааны онцлогоос урган гарч буй асуудал юм.

Япон улсаас сүүлийн жилүүдэд Монголд хэрэгжүүлж буй дипломат бодлогын амжилтаас суралцах зүйл цөөнгүй байна. Монгол дахь Японы тэрхүү “Засгийн газрын хөгжлийн тусламж”-ийн голлох хэлбэр нь хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж, техникийн хамтын ажиллагаа. Зорилго нь хүмүүнлэгийн үзлийг хэрэгжүүлэх, аюулгүй байдал, энх тайваны олон улсын орчныг бүрдүүлэх, дэмжлэг авагч улсын ашиг сонирхлыг анхаарах, Японы имижийг сайжруулж, халдан

түрэмгийлэгчийн муу талын нөлөөг арилгахад оршиж байсан, байсаар ч байна.

Дээрхийн адил “Эдийн засгийн тусламж ус мэт урсаж, соёлоор нэвтрэн хүний сэтгэлийг татах” япон арга Монголд маш өргөн хүрээнд явагджээ. Монгол руу чиглэсэн японы сүмогийн бодлогыг жишээ болгож болно. Жил бүр Японы талаас монголын хүүхдүүдийг японд сүмогийн сургалтад хамруулан, улмаар сургалтын үр дүнд сүмогийн ёкузона цолыг хүртэл олгож байгаа нь монгол хүн япон хүнтэй ойр дотно харилцаатай болох, тэгснээрээ Японд талархах сэтгэлийг дэвэргэж бэхжүүлж

соёлын өвд бүртгүүлсэн нь хамтын ажиллагааны сонгодог амжилт юм.

Үүний зэрэгцээ 1990-ээд оноос хойш манай улсын Өвөр Монголын монгол хэлний суваг болон Монгол, Хятадын хамтарсан хөрөнгө оруулалттай Сансар кабелийн телевиз Монголд нээгдэж, түүх, урлаг уран сайхан, спорт, мэдээлэл, цаг үеийн хөтөлбөрүүдийг хүргэж эхэлсэн нь Монголын үзэгчдийн сонирхлыг татаж, энэ талаар хоёр тал хамтын ажиллагаагаа хөгжүүлэхэд болон Монголд биднийг сурталчлах сайхан боломжийг бүрдүүлсэн. Хятад, Монгол хамтарсан хөрөнгө оруулалттай Сансар

“Хятадын талын буцалтгүй тусламжаар монгол оюутныг сургах хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө” зэрэг нь хоёр орны боловсролын салбарын хамтын ажиллагааг шинээр урагшлуулж байна. Монголын холбогдох албаныхны мэдээллээр бол, 2010 оны байдлаар Хятадад албаны шугамаар суралцаж буй оюутан болон өөрийн зардалаар суралцаж буй оюутны тоо гурван мянга гаруй болсон байна. Тэдний нэлээд хэсэг нь цаашид хоёр улсын сайн хөршийн найрсаг хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулах болно. Иймд хамтарсан найрамдалт арга хэмжээгээр тэдний ажлыг бэхжүүлэх хэрэгтэй.

Хятад, Монголын харилцаа хөгжиж байгаа ба Хятадын олон улсын байр суурь бэхжиж байгаатай холбоотойгоор Хятадад сурч буй монгол оюутны тоо нэмэгдэхийн зэрэгцээ монголчууд мөн хятад хэл сурах нь нэмэгдэж байна. Орос болон англи хэл бол Монголын залуучуудын хамгийн эхэнд сонгодог хэл байсан үе өнгөрч, одоо цөөнгүй монгол хүүхэд хятад хэлийг сонгон сурч, сурах хүний тоо англи хэлний дараа орж байна. Монголын холбогдох албаны статистикаар Монголын 41 их дээд сургуульд болон 14 дунд сургуульд хятад хэлний хичээл орж 2600 гаруй хүн сурч буй гэсэн статистик мэдээ байна. Хятад хэлний сургалтын төв үүнд ороогүй. Монголын залуучуудын хятад хэл сурах эрмэлзэл нэмэгдэж буйтай холбоотойгоор Ерөнхий сайд Вэнь Зябао ирэх таван жилд 2000 оюутан сургана гэдгээ Монгол Улсын Засгийн газарт амлажээ. Мөн 300 залууг Хятадад аялахыг урьсан. Мөн Ерөнхий сайд С.Батболдтай хамт Хятадын соёлын төвийн нээлтийн арга хэмжээнд оролцсон. Энэ нь Хятадын Засгийн газрын гадаад дахь ес дэх соёлын төв, хоёр орны ард түмэн хоорондын харилцан ойлголцол, найрамдлын шинэ тавцан болно гэдэгт итгэлтэй байна.

Дээр дурдсанаас зөвхөн одоо байгаа асуудлуудыг анхаарч, холбогдох бодлогыг хэрэгжүүлснээр харилцан ойлголцол нэмэгдэнэ. Монгол руу чиглэсэн гадаад харилцаандаа Хятадын эдийн засгийн болон “зөөлөн хүч”-ний боломжийг нэгтгэвэл монголчуудын хятадаас сэрэмжилсэн, хардсан үзэл аажим аажмаар алга болно хэмээн үзэж байна. Мэдээж энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд яарах хэрэггүй, хоёр орны улстөрчид, холбогдох албад, судлаачдын мэдлэг, идэвхи хэрэгтэй. Хоёр орны урт удаан хугацааны эрх ашгаас гарсан эрүүл, бодит хандлагаас асуудлыг шийдвэрлэх арга замыг хайцгаа. Тэр бол Хятадын Монгол руу чиглэсэн стратегийн хэрэгцээ шаардлага гэдгийг л ойлгох хэрэгтэй. Энэхүү макро том зорилтыг хэрэгжүүлж, харилцан итгэлцлийг бэхжүүлэх нь маш чухал байна.

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

“Засгийн газрын мэдээ” сонин нь ардчилсан, шударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэм хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилгоо болгоно.

ТУЗ-ийн дарга
Эрдэнэбаатарын ДОЛГИОН

Тэргүүн орлогч эрхлэгч
Цэвээндолгорын ЦЭВЭЭНХЭРЛЭН
Утас: 99901526

Орлогч эрхлэгч
Лхагважавын СУГАРМАА
Утас: 99903584

РЕДАКЦИ

Улс төр, нийгмийн мэдээллийн алба
Эдитор Б.Гэндэлзор
Утас: 99901483

Эдийн засаг, бизнес мэдээллийн алба
Эдитор Б.Баяртотгох
Утас: 99901532

Гадаад контент, соёл энтэртайментын алба
Эдитор Р.Оюунцэцэг
Утас: 99901621

ЗАР СУРТАЛЧИЛГАА

Г.Лхагвасүрэн
Утас: 99903581

ХАЯГ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
I хороо, Энхтайвны өргөн чөлөө,
“Бло Скай тауэр” 407 тоот
Улсын бүртгэлийн дугаар: 1024
Утас: 70103131,
Факс: 70106065

ЦАХИМ ХУВИЛБАР

Zasag.Co
“Чөлөөт хэвлэл”
сангийн хэвлэх үйлдвэрт хэвлэв

Дугаарын удирдагч
Б.Баяртотгох

ЗГМ: Сэдэв

Хамгийн зөв шийдэл нь сурагчдын автобус

Э.Бат-Уул хотын Засаг дарга байхдаа нэгэн чухал ажлыг эхлүүлсэн нь сурагчдын автобус. Замын түгжрэл бууруулахаас гадна сурагчдын аюулгүй байдлыг хангах үндсэн зорилготой. Тэрхүү хичээлийн жилд 33 сургуулийн 104 автобус өдөрт 3424 сурагчдад үйлчилж байжээ. Ийм тооны хүүхэд хичээлдээ ирж, буцахдаа санаа зоволтгүй болсон гэсэн үг. Тэгвэл 2016-2017 оны хичээлийн жилд долоон дүүргийн гурван цэцэрлэг, 51 сургуулийн 7626 сурагчид (давхардсан тоогоор) 128 автобус үйлчилж байна. Анх эхэлж байсантайгаа харьцуулахад нэлээд ахиц гарсан байгаа биз. Гэхдээ л хангалтгүй хэвээр.

Ядаж хүйтний улиралд сурагчдын автобусны хүртээмжийг нэмэгдүүлмээр байна



Б.Ганбаяр/ЗГМ©

Улсын хэмжээнд хагас сая гаруй хүүхэд ерөнхий боловсролын сургуульд суралцаж байна. Тэдний 40 гаруй хувь нь зөвхөн нийслэл хотод төвлөрдөг. Нийслэлийн сурагчдын ихэнх нь гэрийнхээ ойролцоо сургуульд явдаг болохоор тусгай автобус шаардлагагүй байх. Гэхдээ тэдний дунд хоёр, гурван км-ын алсаас сургууль руугаа явдаг, хол гэртэй хүүхэд цөөнгүй. Зарим сургууль гурван ээлжээр хичээллэдэг болохоор хичээл тарах үед харанхуй болчихно. Тэгээд өвлийн үйртнээр, түнэр харанхуйд айж сандарсаар гэрийн зүг гэддэрнэ. Өрөвдөлтэй биш гэж үү. Уг нь тэд хичээлээ тараад шууд

автобусандаа сууж, гэрийнхээ ойролцоо хүргүүлдэг бол хэн хэндээ амар байхсан. Гэвч өнөөх л хөрөнгө мөнгөний асуудлаас шалтгаалаад бүх сургуулийг автобусаар хангаж чадахгүй байна.

Сурагчийн автобус яагаад хэрэгтэйг тайлбарлахын тулд ганц жишээ дурдъя. “Хобби” сургууль 10 автобустай. Эдгээр автобус тогтсон маршрутаар явж, хүүхдүүдээ сургууль дээр авчирна. Хичээл тарсны дараа гэрийнх нь ойролцоо хүргэж өгнө. Нэг автобусанд 25 хүүхэд сууна гэж бодвол 250 сурагч тэрхүү

үйлчилгээнд хамрагджээ. Хэрэв энэ сургууль тусгай автобусгүй байсан бол 250 машин хүүхдээ хүргэж өгөх гээд сургуулийн гадна шавааралдана гээд төсөөл дөө. Тэр хавьдаа бөөн түгжрэл үүсэх нь тодорхой.

Өдгөө 128 автобус сурагчдыг зөөж байгаа талаар эхэнд өгүүлсэн. Гэхдээ нийт автобусны 70 гаруй хувь нь хувийн сургуулийнх гэдгийг анхаарах хэрэгтэй. Тэд компаниудтай гэрээ байгуулж, нэгдсэн журмаар автобусаа түрээсэлдэг. Харин улсын сургуулиудын 28 нь л сурагчаа зөөх автобустай болжээ. Энэ тоог

нэмэх ёстой гэдэгтэй бүгд санал нийлдэг ч ажил хэрэг болгосон нь үгүй.

“Улсын сургуулиуд автобусны үйлчилгээ авья гэсэн хүсэлт их ирүүлдэг. Гэхдээ хүсэлт ирүүлсэн болгонд хуваарилах боломжгүй л дээ. Тухайн сургууль хэдэн явдаг вэ гэсэн судалгаа гаргасны үндсэн дээр шийдвэрлэнэ. Бид дүүргүүдийн боловсролын газраар дамжуулан судалгаа авсан. Судалгаан дээр үндэслэн автобус хамгийн их шаардлагатай гэж үзсэн 23 сургуулийн хүсэлтийг нийслэлийн ЗДТГ-т хүргүүлсэн.

Бүтэн хичээлийн жилийн турш биш юм аа гэхэд ядаж хүйтний улиралд сурагчдын автобусны хүртээмжийг нэмэгдүүлмээр байна” хэмээн нийслэлийн Боловсролын газрын эрүүл ахуй, аюулгүй байдлын хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн Б.Энхтайван хэлсэн юм.

Нэгэн тоо баримт сонирхуулья. Өнгөрсөн жил зам тээврийн ослын улмаас 50 хүүхэд нас баржээ. 244 хүүхэд хүнд, хөнгөн гэмтсэн байна. Тэдний дийлэнх нь сургууль, гэрийн хооронд явж байгаад осолд өртсөн болохыг Замын цагдаагийн

албаны статистик мэдээнд харж болно. Үүнээс гадна харих замдаа бусдад зодуулж дээрэмдүүлсэн, нохойнд хазуулсан, унаад хөл гараа гэмтээсэн тохиолдол хэд байгааг тооцох аргагүй. Эцэг, эхчүүд нь ажилтай байдаг тул хүүхдээ өдөр бүр сургуулиас авна гэж бүр ч горьдолтгүй. Ингээд болохоор сурагчдын автобус л хамгийн зөв гарц байгаа юм. Эрх бүхий албан тушаалтнууд нь энэ асуудалд дорвитой анхаарч, хүйтэнд даарч яваа хүүхдүүдээ автобустай болгоод өгвөл олон хүн баярлана даа. [ЗГМ]

ЗГМ: ТОДРУУЛГА

Г.Отгонтамир: Улсын сургуулийн автобусны тоо хангалтгүй хэвээр байна

Замын цагдаагийн албаны Урьдчилан сэргийлэх, олон нийттэй харилцах хэлтсийн мэргэжилтэн, цагдаагийн ахлах дэслэгч Г.Отгонтамираас дараах зүйлийг тодруулав.

-Сурагчдын автобусны стандарт танай алба хяналт тавьдаг уу?

Замын цагдаагийн алба тухайн тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал, стандарт хэрэгжилтийг хангуулах чиглэлээр хяналт тавьж ажилладаг. Бид хичээлийн шинэ жил эхлэхийн өмнө нийслэлийн Тээврийн газар болон Авто тээврийн үндэсний төвтэй хамтраад сургуулийн автобуснуудад хяналт шалгалт хийсэн. Энэ үзлэгээр стандартад тэнцсэн автобус ховор. Улсын хэмжээнд байдаг 139 автобусны 20 гаруй хувь нь л стандартад тэнцсэн байдаг. Ихэнх нь насжилтаараа тэнцээгүй.

Бид одоо хүүхдийн зорчигч тээврийн талаар судалгаа хийж байгаа. Судалгааны үр дүнд хүүхдийн зорчигч тээврийн нэгтгэл байгуулбал ямар вэ гэсэн санаа гарч ирж байна. Улаанбаатар хотод байгаа 139 автобус нэгдсэн баазад байрладаггүй. Тиймээс техникийн бүрэн бүтэн байдал алдагдсан уу, жолооч согтууруулах ундаа хэрэглэсэн байна уу гэдгийг хянах боломжгүй байгаа юм. Харин хүүхдийн зорчигч тээврийн нэгтгэлтэй болчихвол сургууль бүрийг хүүхдийн зориулалтын автобусаар хангаж, нэгдсэн журманд оруулах боломжтой. Мөн замын хөдөлгөөний ачаалал эрс багасна.

-Энэ хичээлийн жилд сурагчийн 130 орчим автобус явж байвал хэрэгцээ шаардлагыг хангаж чадах бол?

Улсын сургуулийн хувьд хүүхдийн автобусны тоо хангалтгүй

хэвээр. Гэхдээ нийт хэдэн автобус шаардлагатай вэ гэсэн тоог гаргахын тулд нарийн судалгаа хийх ёстой. Нийслэлийн бүх сургуулийн удирдлагатай уулзаж, автобусаар зорчих шаардлагатай хүүхдийн тоог гаргана. Дараа нь маршрутаа нарийн зохионо.

-Хүүхдийн сургууль амарснаас хойш замын хөдөлгөөний ачаалал эрс багассан нь анзаарагдаж байна. Ер нь түгжрэл ойролцоогоор хэдэн хувь буурсан бол?

Улаанбаатар хотын хэмжээнд өглөөний 7-11 цагийн үед замын хөдөлгөөний ачаалал эрс нэмэгддэг. Одоогийн байдлаар хөдөлгөөний ачаалал 30-40 хувь буурсан байна. Сургуулийн амралт эхэлсэн нь яах аргагүй нөлөөлсөн. Сургуулийн сурагчдыг нэгдсэн журмаар автобусаар зөөвөл хөдөлгөөний ачаалал хэрхэн буурах нь эндээс харагдаж байгаа байх. [ЗГМ]

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ

Г.Доржпалам: 61 хувь нь стандарт шаардлагад нийцдэггүй

Нийслэлийн Тээврийн газрын орлогч дарга Г.Доржпаламтай уулзаж, сурагчдын автобусны талаар ярилцлаа.

-Нийслэлийн өмнөх удирдлагууд сургуулийн сурагчдыг автобусаар тээвэрлэх ажлыг эхлүүлсэн. Энэ ажил ирэх дөрвөн жилд үргэлжлэх үү?

Замын ачааллыг бууруулах, хүүхдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор 2012-2013 оны хичээлийн жилд сурагчийн буюу хүүхдийн автобус явуулж эхэлсэн байдаг. Нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад тодорхой үүрэг, чиглэл өгч, алслагдсан гэр хорооллууд руу түлхүү явуулсан юм. Нийслэлийн одоогийн удирдлага мөрийн хөтөлбөртөө сургуулийн насны хүүхдүүдийг үнэ төлбөргүй

зорчуулах, тэдний аюулгүй тээвэрлэлтийг хангах нөхцөлийг бүрдүүлнэ гэж тусгасан. Тиймээс энэ ажил үргэлжлээд явна гэсэн үг. Одоогоор 128 автобусаар 7626 сурагчийг тээвэрлэж байгаа. Цаашдаа хүүхдийн автобусны үйлчилгээ, хүртээмжийг дээшлүүлэх, шинэ нөхцөл байдлыг судлах гээд олон ажил хийгдэнэ.

-128 автобус гэдэг хангалтгүй тоо. Энэ тоог нэмэгдүүлэх боломж хэр байна вэ?

Сургуулиудын зүгээс хүүхдийн автобусны үйлчилгээг өргөжүүлж өгөөч гэсэн хүсэлт их ирдэг. 2014, 2015 онд улсын болон орон нутгийн төсвөөр 40 автобус худалдан авч, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд сурдаг сургуулиудад өгсөн. Уг нь стандартын дагуу 10-аас доош жил явсан автобус

сургуулийн хүүхэд тээвэрлэх ёстой. Гэвч энэ хичээлийн жилд явж байгаа автобусны 61 хувь нь энэ шаардлагад нийцэхгүй байгаа. Тиймээс төр засаг парк шинэчлэлд анхаарах хэрэгтэй.

-Парк шинэчлэлд хэдэн төгрөг шаардлагатай вэ. Энэ мөнгийг ямар эх үүсвэрээс олох боломжтой бол?

Яг тэдэн төгрөг хэрэгтэй гэсэн нарийн тооцоо алга. Нийт 100-гаад сургууль автобус хэрэгтэй гэсэн хүсэлтээ ирүүлсэн. Харин ямар маркийн автобус аль улсаас авахаас шалтгаалаад үнэ нь янз бүр. Европын орнуудаас авья гэвэл үнэ нь хэтэрхий өндөр. Хятад, Солонгосоос авахаар бол 100 орчим сая төгрөг болно. Автобус нь байхад эцэг эхчүүд тодорхой хэмжээний хөлсийг нь төлөөд хүүхдээ явуулах хүсэлтэй байдаг. [ЗГМ]

ЗГМ: НЭГ АСУУЛТ

Сургуулийн нэгдсэн автобустай болохыг та дэмжиж байна уу?



Баянзүрх дүүргийн 4 дүгээр хорооны иргэн Г.Оюунцэцэг
-Хэн ч гэсэн хүүхдээ аюулгүй автобусанд суулгахын хүснэ. Манай гэрийн ойролцоо ийм сургуулийн автобусаар явдаг хүүхдүүд байдаг. Эцэг, эхчүүд ч сэтгэл амар ажилдаа явна шүү дээ. Улсаас зарим зардлыг нь гаргаад, эцэг эхчүүдээс мөнгө татна гэсэн ч татгалзахгүй. Гэхдээ улсын сургуульд ийм нэгдсэн автобус их ховор байдаг гэсэн.

Сонгинохайрхан дүүргийн 5 дугаар хорооны иргэн Э.Түмэнжаргал

-Дэмжиж байна. Сургуулийн хүүхдүүд амарсан үеэр замын түгжрэл эрс багассан байна. Хэрэв сургуулиуд нэгдсэн автобустай болчихвол замын ачаалал буурах нь гарцаагүй.



Тэгээд ч хэдэн хүний ажлын байр нэмэгдэнэ. Харамсалтай нь нэгдсэн автобустай сургууль маш ховор байдаг.



Баянгол дүүрэг 3 дугаар хорооны иргэн С.Гэрэлтуяа
-Би Дарь-Эхийн автобусны буудлаас хотын төвийн сургууль руу явдаг байсан. Тухайн үед өнөөдрийг бодвол аюул багатай байлаа. Орой хичээлээ тараад харьж яваа хүүхүүд гэмт хэрэгт өртөх магадлал өндөр байдаг. Бүх


сургууль нэгдсэн автобустай болох нь зөв. Ядаж л хүүхдүүд агаарын бохирдол ихтэй оройн цагаар алхахгүй, замын осолд өртөхгүй шүү дээ.



Хан-Уул дүүргийн 15 дугаар хорооны иргэн Ц.Наранцэцэг
-Би АНУ-д олон жил амьдарсан. Нэгдсэн автобус гэдэг сургуульд байх ёстой үйлчилгээний нэг болчихсон байдаг. Хэрэв сургуулиас нэг милийн зайтай амьдардаг бол автобусаар үйлчилдэггүй. Манай улс хэзээ нэгэн цагт ийм тогтолцоотой болох байх. Гэхдээ өнөөдрийн нөхцөл байдлыг харвал ойрын хэдэн жил хэрэгжихгүй нь. Сургуулийн автобусын тоо нэмэгдлээ гээд агаарын бохирдол төдийлөн нөлөөлөхгүй. Тиймээс эсэргүүцэх зүйл алга. [ЗГМ]

ЗГМ: ИНФОГРАФИК

2016-2017 оны хичээлийн жилд 7 дүүргийн 51 сургуулийн 7626 суралцагчийг 128 автобусаар тээвэрлэж байна.



Нийслэлийн Боловсролын газар©

Залуус

Н.Цацрал: Загвар, карьерээс илүү боловсролыг чухалчилсан

Загвар өмсөгч

гэхээр заавал өндөр, туранхай, хөөрхөн байх албагүй

Б.Бямбасүрэн
@byambaZGM

Загварын ертөнцийн гал тогоонд нэр хүнд, атаархал, эрх мэдэл, мөнгө гээд алив бүхэн өрнөж байдаг гэлцдэг. Загвар өмсөгчийг хоосон толгойтой, гангалахаас өөр юм мэдэхгүй хэмээн шүүмжилдэг. Нийгмийн дунд ч тэдний талаарх энэ мэт ойлголтууд ёс мэт тогтож, тэднийг эрх мэдэлтэй, мөнгөтэй хүмүүсийн утсан хүүхэлдэй болдог мэтээр ойлгодог. Гэвч уулын мод урттай богинотой байдгийн адилаар тэдний дунд өөрийн хүч чадлаар амжилт өөд тэмүүлж яваа “Монгол модел” агентлагийн загвар өмсөгч Н.Цацралыг бид энэ удаагийн “Залуус” буланд аяар урьж, ярилцлаа. Бид Монголын загварын ертөнц болон түүний үзэл бодлын талаар яриа өрнүүлээ.

-Загварын ертөнцөд хэзээ хөл тавьсан бэ. Багаасаа л загвар өмсөгч болох сонирхолтой байсан уу?

-Би их бөгтийж явдаг, дотогшоо алхаатай охин байсан. Ээж маань эмэгтэй хүүхэд гоо сайхандаа анхаарах ёстой гэж зөвлөснөөр анх “Эра” төвийн загварын дамжаанд 14 настайдаа явж эхэлсэн. Ингээд загвар надад улам их таалагдаж, одоо “Монгол модел” агентлагт загвар өмсөгчөөр ажиллаж байна.

Багадаа эмч болно гэж их мөрөөддөг байлаа. Арван жилдээ 33 дугаар сургуульд сурдаг байсан юм. Сургуулийнхаа хинийн сонгонд орох талаар боддог байсан ч анги дэвших тусам санаа сэтгэл өөрчлөгдсөн. Ахлах ангид ороод менежер хүний ажил илүү сонирхолтой санагдаж эхэлсэн. Тиймээс англи хэлний сонгонд явсан нь миний хамгийн зөв алхам байсан юм болов уу гэж боддог. Менежерээр сурахад англи хэлний мэдлэг нэлээд тус болж, их сургуульд тэнцсэн байх.

-Би таныг арван жилээ төгсөөд л загвар өмсөгч болсон юм байна гэж ойлгоод байлаа. Дээд боловсролоо ямар мэргэжлээр хаана эзэмшсэн бэ?

-Мэдээж хэрэг загвар бол миний дуртай зүйлүүдийн нэг яах аргагүй мөн. Гэхдээ



С.Батсайхан / ЗГМӨ

Монголд дан ганц загвараар амьдраад явах боломжгүй шүү дээ. Тиймээс дунд сургуулиа төгсөөд мэргэжил эзэмшихээр МУИС-ийн Олон улсын худалдааны менежментийн ангийг 2013 онд дүүргэсэн. Эзэмшсэн мэргэжлээрээ Монголд дахь “Манго” брэндийн дэлгүүрт худалдааны менежерээр ажилд орсон. Анх Улсын их дэлгүүрт нээгдэх үед нь гадагшаа сургалтаар явж, брэнд гэж юу байдаг, хэрхэн ажилладаг талаар ойлголт авч байлаа. Одоохондоо төрөөд удаагүй болохоор хүүхдээ харж байна. Удаагүй ажилдаа орно.

-Гэр бүлийнхээ талаар танилцуулахгүй юу. Хотод торж, өссөн үү?

-Багадаа Налайхын цаахна талд байрладаг Городок гэдэг газар өссөн. Намайг зургаан нас хүрэх үед манайх хотод нүүж ирсэн юм. Аав маань цэргийн нисгэгч хүн. Одоо тэтгэвэрт гарчихсан. Харин ээж хими, биологийн багш. Нэг ахтай. Тэд маань ах бид хоёрыг төрөл

бүрийн дугуйлан дамжаанд их явуулсан. Одоо бодоход өөрийгөө хөгжүүлэх боломжийг олгодог байжээ. Тиймээс миний үзэл бодол харьцангуй эрт төлөвшсөн байх. Хүүхдүүдийг багаас нь завгүй байлгаж, дуртай зүйлийг нь дэмжиж өгвөл буруу замаар орох, цаг заваа дэмий зүйлд үрэхгүй байх гээд чухал нөлөөтэй. Ээж болоод удаагүй болохоор охиноо ч гэсэн ингэж хүмүүжүүлнэ. Нөхөр бид хоёр нэг нэгнээ хар багаасаа л мэднэ. Манай хүн график дизайнер

Миний амьдралын сайхан зүйлүүдийн ердөө л нэг нь загвар

мэргэжилтэй.

-Багаасаа л загварын гал тогоонд байсных гэр дотор юу

Одоо үед мэргэжлийн загвар өмсөгч гэж ярьдаг болсон. Энэ ч утгаараа мэргэжлийн түвшинд хүрсэн учраас мэргэжил гэж хэлнэ.

суртахуунтай л холбоотой.

-Томоохон загварын шоунд ороход ямар шаардлага тавьдаг вэ?

-Дизайнеруудын сонголт мэднэ. Жишээлбэл, нэг нь олон жил ажилласан моделтой хамтрах сонирхолтой байдаг бол нөгөө нь цоо шинэ дүр төрх хайдаг. Шоу болохын өмнө casting буюу шалгаруулалт болдог. Бүгдийг нь алхуулна, хувцасаа өмсүүлж үздэг. Мөн томоохон “Торго”, “Гоёл” шоунд ороход байнгын бэлтгэл сургуулилт хийдэг.

-Загвар өмсөгч хүн ямар байх ёстой вэ. Энэ мэргэжил мөн үү?

-Одоо үед мэргэжлийн загвар өмсөгч гэж ярьдаг болсон. Энэ ч утгаараа мэргэжлийн түвшинд хүрсэн учраас мэргэжил гэж хэлнэ. Сүүлийн үед мэргэжлийн загвар өмсөгчид гадаад руу гарч байна. Загвар өмсөгч гэхээр заавал өндөр, туранхай, хөөрхөн байх албагүй. Энэ бол жинхэнэ хэмжүүр биш. Хамгийн гол нь дизайнерийн гаргахыг хүссэн зүйлийг илэрхийлж, хувирч чаддаг байх хэрэгтэй. Тухайлбал, фото модельн чиглэлээр яваа охид заавал өндөр байх шаардлагагүй шүү дээ.

-Загварын шоуны дараа өөрт таалагдсан, эсвэл өмссөн хувцасаа авмаар санагддаг уу?

-Таалагдсан хувцасаа дизайнерт хэлээд хямдруулаад авах боломж бий. Гэхдээ зохион бүтээгчийн маш их ур, хүч хөдөлмөр шингэсэн байдаг учраас хүний бүтээлийг үнэлэх нь зүйтэй. Зарим тохиолдолд

тухайн хувцас үнэхээр их таалагдаж байвал ижил загварыг арай хямдаар хийлгүүлэх боломжтой байдаг.

-Mongolia's next top model тэмцээнд орох бололтой байна уу?

-Уг нь оролцоно гэж бодож байсан юм. Харамсалтай нь, оролцогчид удаан хугацаагаар байшинд байрлана гэдгийг дуулаад энэ бодлоо орхисон. Одоохондоо охин маань ой таван сартай, жаахан байна. Энэ их утаатай, ханиад томуу ихтэй үед өөрөө харж, эрүүл саруул өсгөх нь чухал гэж үзсэн учраас больсон доо.

-Ээж хүний хувьд агаарын бохирдолд ундууцаж л байгаа байх?

-Өдрийн цагаар хүүхдээ гадаа гаргахаа больсон. Долоо хоногт нэг удаа хотоос гадагш агаарт гарч байна. Миний бодлоор барилгын салбар уналтад ороод байгаа энэ үед гэр хорооллын иргэдийн хашаа байшинг үнэлээд, зарагдахгүй байгаа орон сууцаар сольж болохгүй гэх газаргүй. Хоосон газар дээр нь утааны эсрэг төсөвлөсөн мөнгөөрөө орон сууц барьж, хөрөнгөө нөхөж олох боломж бий. Энэ мэт арга хэмжээг яаралтай авахгүй бол зарим айл хог, дугуй шатааж байна. Үүнээс болж хорт хавдар үүсэх эрсдэлтэй гэдгийг сонсоод би маш их эмзэглэсэн. Манай улс хорт хавдарын нас баралтаар дэлхийд дээгүүрт бичигдэж байгаа нь агаарын бохирдолтой салшгүй холбоотой. Гэхдээ залуу гэр бүлийн хувьд дараа жил энэ байдал арай дээрдэг, гамшгийн хэмжээнээс буурах байх гэж найдаж байна.

-Таны цаашдын зорилго юу вэ. Олон улсын загварын тайз уу?

-Боломж нь олдвол гадагшаа тэмцээн уралдаанд явна. Мэдээж хэрэг загварын талбарт байгаагийнх өөрийгөө илүү сорих боломж олдвол татгалзахгүй. Гэхдээ бүх зүйлээ орхиж, улайрч нэг зүйлийн төлөө зүтгэхгүй. Амьдрал баялаг гэдэг. Өөр илүү олон сайхан зүйл хийхээр төлөвлөж байгаа. Модел бол миний амьдралын олон сайхан зүйлүүдийн ердөө л нэг нь. Хамгийн ойрын зорилго гэвэл эрхэлсэн ажилдаа амжилт гаргах юм.

Мөрөөдлийн тухайд нөхөр бид хоёрт хийхийг хүссэн маш их зүйл бий. Тэрэндээ хүрэхийн төлөө одооноос бага багаар хөдөлмөрлөж, суралцаж байгаа. Минийх гэхэд хувцас загварын өөрийн гэсэн брэндтэй болох. Харин нөхөр хөгжим бүжгийн талаар мэдрэмжтэй учир залуусын цугладаг тийм буйдхан газартай болохыг хүсдэг.

-Ярилцсанд баярлалаа. [ЗГМ]

UBshop.mn

ЧӨЛӨӨТ ХУДАЛДААНЫ ПЛАТФОРМ

Юу авмаар байна? Юу зармаар байна?

АВТОМАШИН

1 Ачааны зориулалттай автомашин маш хямд зарна
Утас: 96481125, 99087992

2 Автомашины хагарч цуурсан шил наагч зарна.
Утас: 99679962

3 Сая орж ирсэн гаалийн бичигтэйгээ байгаа автомашиныуд зарна.



Хаан, Хас, ХХБ, Банк болон банк бусын Лизингээр авч болно. "Prius 11, 20, 30, Estima"
Утас: 91113532

КОМПЬЮТЕР БА ДАГАЛДАХ ХЭРЭГСЭЛ

1 Гэр болон оффиссын сүлжээ хүрдэггүй газарт сүлжээ дахин дамжуулагч суурилуулна.
Утас: 75752020

2 Black iPad mini Wi Fi 64GB багтаамжтай. Үнэ: 400.000 төгрөг
Утас: 88998138

3 Ipad-1 wifi 16gb зарна.
Утас: 99002508

4 Төмөр гадаргуутай 2TB багтаамжтай зөөврийн hard диск зарна.
Утас: 98886655

5 "Sony Vaio core i5" notebook хямд зарна.
Үнэ: 500.000 төгрөг
Утас: 88102740

ҮЛ ХӨДЛӨХ

1 Ар хустайн зусланд цэвэр агаарт хаус зарна. 2011 онд ашиглалтанд орсон төмөр бетон суурь, төмөр бөс бетон, 38-ийн дан тоосго, гадна талд хөөсөөр дулаалсан 200м2, 2давхар, машины гражтай, 380в худагийн ус гарсан цэвэр устай, халуун устай, цэвэр бохироо бүрэн шийдсэн өвөл зуны дулаахан чанартай сайн барьсан. - Нийт 6 өрөө, гал тогоо, зочны өрөө, 2 ариун цэврийн өрөөтэй, гал тогоо 00-д халуун устай, вакум цонх, паркетин шалтай дотор интерьер засал сайн.
Утас: 99289768

2 10-р хороололд Сувилахуйн сургуулийн хойно 47м.кв хоёр өрөө байр зарна. Утас: 88192130

3 Төмөр замд СОТ-н таван давхарт угсармал байрны хоёр өрөө байр зарна. Утас: 99466494

4 Сансарын тунелд 1 давхарын гал тогоо тусдаа 3 өрөө байр зарна. Утас: 99760217, 99101271

НОМ, ХЭВЛЭЛ

1 Бүх төрлийн ном хэвлэл худалдаалж байна.
Утас: 99144154

2 Хуучин номнууд зарна.
Утас: 94640105

3 Бизнес удирдлагын магистерийн ангид хэрэглэгдэх 2003-2008 оны Pearson's international edition номнуудыг тус бүр 30.000 төгрөгөөр зарна.
Утас: 99153637

4 Ээж ба хүүхэд ном зарна.
Утас: 99089401

5 Сэргэн мандалтын үеийн нэрт зураачдын бүтээлийг өнгөтөөр хэвлэж, орос хэлээр нийтэлсэн Монголд цөөн байдаг уран зургийн ном зарна.
Утас: 99625921

6 Official guide of TOEFL TEST 4th edition. Албан ёсны TOEFL тест гаргадаг газраас уг шалгалтад бэлтгэгчдэд зориулан гаргасан GUIDE book-ийн хамгийн сүүлийн хэвлэл. Хэрэглэж байсан мөн дисктэйгээ. Утас: 99674312

7 Өсвөр насныхны дээдэлж мөрдөх 7 зуршил ном зарна.
Үнэ: 30.500

ЦАХИЛГААН БАРАА

1 Электрон жин худалдана. Алт, мөнгөн эдлэл болон эмийн тунг жигнэх зориулалтай. Авсаархан хөнгөхөн. LCD дэлгэцтэй. 200 гр хүртэл Хэмжээ: 115X65X15 мм, Жин: 95 гр 1 минутанд автоматаар унтарна. Тэжээл: 2 AAA батареи (дагалдахгүй) Ажиллах температур: 10-30 хэм (C)
Утас: 88512938, 96012938

ХУДАЛДАНА

ПЯНЗ ХУДАЛДАНА. МОНГОЛ, ОРОС, БУСАД.

УТАС: 95777773

UBSHOP.MN

ubshop.mn сайтад та зараа байрлуулбал манай сонины зарын энэ хэсэгт шууд орох юм. Зөвхөн кирил үсгээр бичсэн, холбоо барих утас, зарах үнэ нь тодорхой зарууд энэ хэсэгт орохыг анхаарна уу.



Авто

**Замын төслийг
Байгаль орчны яам
санхүүжүүлж,
“Colas” компани
хэрэгжүүлжээ**

Г.Очирбат
@ochirbat_ZGM

Францын баруун умардад орших Нормандийн Турувр-о-Перш хэмээх бяцхан сууринд гадаргууг нь нарны зай хураагуурын панелиар бүрсэн автозам туршиж эхэллээ. Watway хэмээн нэрлэсэн уг замын нийт урт нь нэг километр. Нарны панель бүхий талбайн нийт хэмжээ 2800 хавтгай дөрвөлжин метр.

Нарны панелийг дээгүүр нь тээврийн хэрэгсэл өнгөрөхөд тэсвэртэй, дугуйтай барьцалдах чадвар сайтай



Франц нарны зайгаар бүтээсэн автозам туршиж байна

тусгай материалаар бүрсэн байна. Уг замаар өдөртөө 2000 орчим автомашин зорчино. Үйлдвэрлэгчийнх нь тооцоогоор нарны зай хураагууртай зам өдөртөө 280 MegaWatt/цаг эрчим хүч үүсгэх хүчин чадалтай. Үүсгэсэн эрчим хүчийг нь 3400 орчим оршин суугчтай тус хотын гудамжны гэрэлтүүлэгт ашиглах боломжтой талаар Францын Байгаль орчны сайд тайлбарлав. Эрчим хүч

үүсгэдэг замаар гаргаж буй цахилгааны өөрийн өртөг нь дээвэр дээр байрлуулдаг нарын панелийнхаас 13 дахин үнэтэй тусаж байгааг шүүмжлэгчид анхааруулж байна.

Уг замын төслийг Францын Байгаль орчны яам санхүүжүүлж, инженерийн “Colas” компани хэрэгжүүлжээ. Таван сая еврогийн зардал гаргаж бүтээсэн энэхүү өвөрмөц технологи бүхий замыг хоёр жилийн хугацаатай туршиж

шалгана. Францын өмнөд хэсэгтэй харьцуулахад Нормандид жилийн ихэнх нь бүрхэг, нартай цэлмэг өдөр цөөн. Тус бүсэд дунджаар жилийн 44 өдөр нь цэлмэг, нартай өнгөрдөг байна. Туршилт амжилттай болох аваас “Colas” компани зардлыг нь бууруулах замаар ирэх дөрвөн жилд нэмж 1000 километр нарны зай хураагууртай автозам байгуулахаар төлөвлөжээ. Тус компани 2020 он гэхэд ийм зам

Үүсгэсэн эрчим хүчийг хотын гудамжны гэрэлтүүлэгт ашиглах боломжтой

байгуулах өртөг ердийн нарны фермийнхтэй ижил түвшинд буурна хэмээн үзэж байна.

Францын эрх баригчид “Colas”-ийн төлөвлөгөөг дэмжих аваас 1000 километр “Нарны зам” нь таван сая буюу тус улсын хүн амын найм орчим хувийг эрчим хүчээр хангаж дөнгөх юм. “Colas” компани автозамын зориулалттай нарны панел уур амьсгал, орчны өөрчлөлтөд хэр тэсвэртэйг шалгах зорилгоор энэ онд Канад, АНУ, Япон болон Европ, Африкийн нийт 100 орчим газарт туршихаар төлөвлөж байна. [ЗГМ]

ЗАХ ЗЭЭЛ

Японд Prius борлуулалтаар тэргүүлэв

О.Мишээл
ЗГМ

Японы автомашины дилерүүдийн холбоо (JADA), Японы мини автомашины холбоо (JMVA) хамтран тус улсад 2016 онд борлогдсон автомашины статистик тайлан гаргалаа. Уламжлал ёсоор уг статистикийг ердийн хөнгөн тэрэг, кэй автомашин гэсэн хоёр ангиллаар гаргажээ.

Ердийн хөнгөн тэрэгний ангиллын жагсаалтыг Toyota Prius загвар 248258 ширхэг зарагдсан амжилтаар дахин тэргүүллээ. Prius нь 2012 онд Японы хамгийн өндөр борлуулалттай загвараар шалгарсныхаа дараа гурван жил дараалан хоёр, гуравдугаар байр эзэлж ирсэн юм. Харин 2015 оны хамгийн борлуулалттай сайтай загвараар шалгарсан Toyota Aqua хоёрдугаар байранд ухарлаа. Уг загварыг Японд 168208 ширхэгийг борлуулсан байна. Гуравдугаар байранд 125832 ширхэг зарагдсан Toyota Sienta загвар шалгарсан байна. Дөрөв тавдугаар байрыг Honda Fit, Nissan Note загвар эзэлжээ.

Тус улсад урт нь 3.4 метрээс, өргөн нь 1.48 метрээс үл хэтрэх, 660 шоо дөрвөлжин сантиметрээс доош багтаамж бүхий 64 морины хүчээс үл хэтрэх хөдөлгүүртэй автомашиныг “кэй” гэсэн ангилалд багтаадаг. Өнгөрсөн оны хамгийн борлуулалттай кэй загварын жагсаалтын эхний гурван байранд Honda N-BOX, Daihatsu Tanto, Nissan DAYZ загвар шалгарлаа. Энэ гурван загвар нь 2015 онд мөн л эхний гурван байрыг эзэлж байжээ. [ЗГМ]

ЗОХИЦУУЛАЛТ

Буруу талдаа жолоотой машины импортыг хязгаарлана

Баруун талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийн импортыг хязгаарлах тухай Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат Засгийн газрын хуралдаанаар танилцуулав.

Манай улс тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг замын зорчих хэсгийн баруун гар талаар явуулна гэсэн хуультай. Энэ нь жолооны хүрд зүүн талдаа байхаар тооцож хууль, дүрэм, журам, стандарт, замын хөдөлгөөний аюулгүй байдлын бусад үзүүлэлтийг тогтооно гэсэн үг юм.

Гэвч импортоор оруулж ирэх автомашины жолооны хүрдний байрлалд хязгаарлалт тогтоогоогүй учир сүүлийн 10 гаруй жил баруун талдаа жо-

лооны хүрдтэй автомашины импорт эрс нэмэгджээ.


Судалгаанаас үзвэл улсын хэмжээний нийт автомашины 48, Улаанбаатар хотын нийт автомашины 55 хувь нь баруун талдаа жолооны хүрдтэй байна. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад замын үзэгдэх орчин чухал бөгөөд баруун гар талаар жолооны хүрдтэй автомашинаар гүйцэж гүрүүлэх, тойрон гарах үед харах талбай 20-70 градусаар багасдаг нь осол гарахад голлон нөлөөлдөг байна. Өнгөрсөн онд гарсан 41 мянга гаруй ослын 64 хувь нь баруун талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгсэлтэй холбоотой байжээ.

Энэ үеэр танилцуулсан өөр нэг

зүйл нь насжилт өндөр машины импортыг хязгаарлах юм. Олон улсад зургаагаас дээш жилийн насжилттай автомашиныг өндөр насжилттай гэж үздэг. Харин манай улсад бүртгэлтэй автомашины 90 орчим хувь нь энэхүү ангилалд багтаж байгаа аж.

Өндөр насжилттай тээврийн хэрэгслийн тоо буурахгүй байгаа нь агаарын бохирдол, зам, тээврийн ослыг нэмэгдүүлэх шалтгаан болдгийг судалгаанаас харж болно.

Буруу талдаа жолооны хүрдтэй болон насжилт өндөр автомашины импортыг хязгаарлах тухай тодорхой санал, шийдвэр, төсөл боловсруулж, танилцуулахыг холбогдох хүмүүст даалгав. [ЗГМ]



TRANSWEST
MONGOLIA LLC

Your Authorized Komatsu Distributor

EMPLOYMENT OPPORTUNITY

▶ Weld/Machine Shop Supervisor

Ulaanbaatar, Mongolia
Reference Number: WMS0117

Transwest Mongolia is a leading mining equipment distributor that supplies customized solutions to meet the unique requirements of its customers. Transwest Mongolia is a wholly owned subsidiary of SMS Equipment Inc., the largest Komatsu dealer in North America and one of the largest in the world.

We are currently seeking a candidate for the position of Weld/Machine Shop Supervisor based in UB at the UB Service Department.

The Role:

Reporting to the Head of Service Department, this position supervises the Welding and Machine Shop Team responsible for completing the daily service and repair activities in support of the Products marketed by Transwest Mongolia, in a safe and productive manner. The Weld/Machine Shop Supervisor will administer processes and procedures ensuring compliance to all company and customer standards. The key responsibilities include:

- Ensures weld/machine shop team has a clear understanding of their job responsibilities by effective supervision, leadership and conducting regular team position description, performance reviews and providing appropriate feedback.
- Supervises the daily activities of the weld/machine shop team ensuring all repairs are completed to the applicable OEM published procedures, applicable time, quality and cost parameters.
- Establishes a work environment that promotes and encourages employee success.
- Ensures all company policy, systems, and industry related training is delivered to all direct reports as needed.
- Ensure documentation is accurately processed, distributed with internal and external departments as required in a timely manner.
- Review all necessary data entry and confirmation is accurate for short and long term recording.
- Works with the planning team to ensure all planned work and scheduled labour plans are executed.

Qualifications:

- Knowledge of Heavy Equipment and Components (5+ Years' experience as Senior Welder)
- Supervisory skills
- Knowledge of Microsoft Office Suite Ability to learn new systems and processes.
- Knowledge of Machining principles, experience operating lathes, milling machines, Horizontal Floor Bores and general machining
- Strong ability to communicate in English, written and verbal

All interested applicants should submit their resume and cover letter referencing the applicable position number in English by **5:00PM, January 15, 2017 to: careers@transwest.mn**

Transwest Mongolia thanks all applicants for their interest, but only short listed candidates for an interview will be contacted.

Transwest Mongolia provides a non-smoking environment

ЗАСГИЙН ГАЗРЫН
МӨГӨӨ
СОНИН УМН

НЭЭЛТТЭЙ АЖЛЫН БАЙРАНД УРЬЖ БАЙНА

ДИЗАЙНЕР:

ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- Мэргэжлийн чиглэлээр их дээд сургууль төгссөн
- Мэргэжлээрээ ажиллаж байсан туршлагатай
- Photoshop, Corel Draw, InDesign, Illustrator болон бусад мэргэжлийн программууд дээр ажиллах чадвартай
- Англи хэлний зохих түвшний мэдлэгтэй

ЕРӨНХИЙ ШААРДЛАГУУД:

- Бүтээлч сэтгэлгээтэй, шинийг санаачлагч
- Хариуцлагатай
- Тогтвор суурьшилтай ажиллах хүсэл эрмэлзэлтэй
- Ажлын ачаалал даах чадвартай
- Хувийн зохион байгуулалт, цагийн менежмент сайтай

БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛУУД:

- Ажилд орохыг хүсэгчийн анкет
- Ажилд орохыг хүссэн өргөдөл
- Гурван үеийн намтар
- Ерөнхий боловсролын гэрчилгээний хуулбар
- Иргэний үнэмлэхний хуулбар
- Их, дээд сургуулийн диплом болон мэргэжлийн үнэмлэхний хуулбар
- 2 хувь цээж зураг (сүүлийн 3 сарын хугацаанд авахуулсан байх)
- Оршин суугаа хаягийн тодорхойлолт
- Өмнө нь ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт

Өргөдлийг “Засгийн газрын мэдээ сонин”-ны байранд ирж бөглөх болон
baasan.b@zasag.co н-мэйл хаягаар явуулна уу. Утас: 7010-3131

Лавлах

МЭДЭЭ 30 мянган тонн мах нөөцөлнө



Г.Оюунтөгс
ЗГМ

Хөдөө орон нутгийн 15 аймгийн 68 суманд өвөлжилт хүндрээд байна. Цаашид цас нэмж ороод хүйтэрвэл нийт 17 аймгийн 127 суманд өвөлжилт болон хаваржилт хүндрэх эрсдэлтэй байгаа гэнэ.

Иймд малчдыг орлоготой байлгах болон хот, суурин газруудад махны хомсдол үүсэх болон үнийг нь нэмэгдүүлэхгүйн тулд мах бэлтгэлийг нэмэгдүүлэх ажлыг шуурхай зохион байгуулахаар болжээ. Юуны өмнө өвөлжилт хүндрэх эрсдэлтэй 17 аймгийн 127 сумын малчдаас 30 мянган тонн махыг хот, суурин газрын хүн амын хэрэгцээнд зориулан худалдан авч нөөцлөхөөр болсон байна. Тэгвэл мах бэлтгэхэд шаардлагатай санхүүжилтийг арилжааны банкуудын эх үүсвэрээр шийдвэрлэх гэнэ.

Харин арилжааны зээлийн хүүгийн төлбөрийг ХХААХҮ-ийн сайдын урамшууллын зардлаас гаргах юм байна. [ЗГМ]

ХУРАЛ Археологичид чуулав



Монголын археологичид Шинжлэх ухаан технологийн их сургуульд хуралдлаа. Энэ өдөр археологичид өнгөрсөн онд хийсэн малтлага, судалгаагаар олдсон олдворуудын талаар хэлэлцсэн юм. Тус хуралд Монголын үндэсний музей, соёлын төв, Түүх-Археологийн хүрээлэн болон ОХУ-ын судлаачид зэрэг 160 гаруй хүн оролцож байгаа аж. Харин энэ удаагийн хурлыг өргөн цар хүрээтэй зохион байгуулж байгааг холбогдох хүмүүс хэлсэн юм. Мөн энэ удаагийн хуралд Орхон аймгийн Жаргалант сумаас олдсон Сянби булшт, Шивээт улааны Түрэг, Уйгурын үеийн хаад язгууртны тахилын онгоны малтлага судалгаа, Ховд аймгийн Мөнххайрхан, Баян-Өлгий аймгаас олдсон хадны оршуулга зэрэг археологийн сор олдворуудыг онцолж байгаа гэв. [ЗГМ]

СОЁЛЫН ӨВ ЮНЕСКО-той хамтарч ажиллана

“Монгол наадам” цогцолбор ОНӨТҮГ, ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комиссын хооронд хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичгийг өчигдөр байгууллаа. Санамж бичгийн хүрээнд “Монгол наадам”-аар дамжуулан улс орноо сурталчлах, аялал жуулчлалыг татах боломжтой аж. Мөн “Монгол наадам цогцолбор” байгууллагын ажилтнуудыг чадавхижуулах, төлөвлөж буй ажлуудаа олон улсын стандарт, шаардлагад нийцүүлэх, “Монгол наадам”-ыг дотооддоо хөгжүүлж гадаадад таниулах болно гэдгийг холбогдох албаны хүмүүс хэлсэн юм. [ЗГМ]

ТВ ХӨТӨЛБӨР

	MNB	Bloomberg	Боловсрол	Монгол ТВ
08.00	09.10 “Өглөө” Монголын уран сайхны кино	07.00 “Японыг судалцаа” нэвтрүүлэг	07.05 “Математикийн Зарчимууд” хүүхэдэд кино	06.30 Өнөө өглөө
12.00	11.40 Монголын зохиолчдын өдөрт. “Манай зохиолчид” баримтат кино 1986 он	11.30 “Шилдэг санаа” нэвтрүүлэг	09.00 “Cook Club” хоолны шоу нэвтрүүлэг	10.00 “Хүүхдийн цаг”
14.00	12.20 Цаг үе, үзэл бодол	14.30 “Удирдагчид Лакуатай хамт” нэвтрүүлэг	13.00 “Англи хэлний” алсын зайн сургалт. Анхан шат	14.00 Спортын шинжлэх ухаан
18.00	13.30 “Пумукл” Германы уран сайхны кино	17.00 “Bloomberg Surveillance” шууд орчуулгын хөтөлбөр	18.05 “Бяцхан оцон шувуу Пороро” хүүхэдэд кино	17.30 “Тог тог” хүүхдийн нэвтрүүлэг
20.00	21.05 “Баасан гараг” цэнгээнт нэвтрүүлэг	20.00 “Блумбергийн ярилцах цаг” нэвтрүүлэг	19.00 “Нисдэг зургаан Луу” ОАК	22.10 “Америкчууд” / season-4/ ОАК
22.00	22.55 “Тэмцэл” Монголын уран сайхны кино	22.00 “Эзэнт гурнийг босгосон нь” нэвтрүүлэг	00.10 “Кино миний амьдрал” нэвтрүүлэг	00.50 “Ингэх гээд байсан юм” МУСК

ОНЦЛОХ ҮЗВЭР “Спартак”



А.Хачатуряны “Спартак” балетыг Улсын Драммын эрдмийн театрт 1984 оны тавдугаар сарын 5-нд тоглож байжээ. Анхны тоглолтод Ардын жүжигчин, хөдөлмөрийн баатар Б.Жамьяндагва хөрвүүлэн дэглэж тайз чимэглэлийг Ч.Гунгаасүх хийсэн байна. Уг балет нь 2000 жилийн тэртээх эртний Ромын соёл, мэсчин боолуудын хэргийг тулаанаар баяр цэнгэл хийгч дарангуйлагчдын амьдралын хэв маяг, зоригт эрийн манлайлан удирдсан боолуудын бослого зэргийг харуулсан эмгэнэлт бүжгэн жүжиг. “Спартак” балет нь жүжигчдээс мэргэжлийн өндөр ур чадвар, нэн ялангуяа “драматизм”-ыг нарийн шаарддаг аж. Ийнхүү хөгжмөөр амьдралын баяр баясгалан, хайр дурлал, дайн тэмцэл, хагачлыг хурц, яруу тодоор илэрхийлдэг гайхамшигт бүтээл гэж дэлхий дахинаа өндөрөөр үнэлэгддэг ажээ. [ЗГМ]

ҮЗВЭР

UB JAZZ LIVE MUSIC CLUB
Украины алдарт саксафончин Дмитрий Таганы “С Саксофоном по жизни” тоглолт энэ сарын 14-нд 20.00 цагт болно.

ҮНДЭСНИЙ ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН

Нийслэлчүүдийг чөлөөт цагаараа цасны спортоор хичээллэн өнгөрүүлэх боломжоор хангах зорилготой “Дэлхийн цасны өдөр”-т та бүхнийг урьж байна. Энэ сарын 15-нд болно.

UB ART GALLERY

“Зэрэгцээ” ертөнц гэрэл зургийн үзэсгэлэн өчигдөр нээлтээ хийлээ. Тус үзэсгэлэн нь нийгэмд болж буй асуудлуудыг хөндсөн аж. Үзэсгэлэн энэ сарын 17-ныг дуустал 10-19 цаг хүртэл үргэлжлэх гэнэ.

МИШЭЭЛ ЭКСПО

“Цагаан сар 2017” үзэсгэлэн худалдаа 50 хүртэлх хувийн хямдрал, урамшуулал зарлаж байна. Энэ сарын 13-16-нд болох сүү, цагаан идээ, тавгийн боов, еэвэн, чихэр, жимс, бууз, банш, мах, махан бүтээгдэхүүн, цар, аяга, таваг, ном, бэлэг дурсгал, үндэсний хувцас гээд олон нэр төрлийн барааг үйлдвэрийн үнээр борлуулах юм.


МОНГОЛЫН УРЧУУДЫН ЭВЛЭЛ

Зураач М.Амартүвшингийн “My Journey in Europe” бие даасан үзэсгэлэн энэ сарын 14-нийг хүртэл үргэлжилнэ.

SPREE CLUB

“Nine Treasures” буюу “Есөн эрдэнэ” хамтлаг энэ сарын 14-ний 19.00 цагт тоглох гэж байна. Тэд “Noise Production”-аас зохион байгуулах металл урсгалын тоглолтуудын салхийг хагалах аж.

ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ



БОСООГООР:

1. Аав, ээжийн аав
2. Буддын гүн ухааныг нэвтэрхий мэдсэн хүнд олгодог зэрэг, цол

3. Баруун Монголын ястан
5. Манлайлагч
6. Аварга махчин загас
7. Ариун цэврийн хэрэгсэл
8. Хятадын

- задгай мөнгө
10. Бүтээмж
11. Билгийн тооллын нэгэн эрин
12. Будаг гардаг улаан чулуу
13. Зорчин явах тасалбар

14. Онгорхой цоорхой

ХӨНДЛӨНГӨӨР:

1. Нийслэл Улаанбаатар хотын анхны нэр
4. Гэрийн аргал түлш хийдэг сав
5. Түвдийн нийслэл
9. Амтат жимс
12. Нэгэн зүйл даавуу
15. Чимээ
16. Италийн мөнгөн тэмдэгт
17. Газар, усны эзэн савдаг
18. Монголчуудын эртнээс хэрэглэж ирсэн

- таних тэмдэг, хээ
19. Хөгжмийн нот
20. Хоёрдугаар хоол
21. Өндөр оргил

ТАШУУГААР:

1. Уучлан хэлтрүүлэх
3. Булчир-хайгаасаа өмхий үнэртэй шингэн ялгаруулдаг нэг зүйл шувуу



Өмнөх дугаарын харуу /01.12

ЗГМ: СҮДОКУ


8		6	3		
		4			1
			9		4
4			5		9
		8	4	3	
6	3		8		
9		1	5		
2				9	7

7	9	5	8	1	6	3	4	2
8	3	2	4	9	5	1	6	7
4	1	6	2	3	7	5	8	9
6	4	3	7	5	9	2	1	8
1	2	8	3	6	4	7	9	5
9	5	7	1	2	8	6	3	4
3	8	1	5	4	2	9	7	6
5	7	9	6	8	1	4	2	3
2	6	4	9	7	3	8	5	1

(Өмнөх дугаарын харуу)

ЦАГ АГААР

УЛААНБААТАР I.13 -16° 6 м/с -27° 4 м/с Багавтар үүлтэй	I.14 -16° 8 м/с -24° 5 м/с Багавтар үүлтэй	I.15 -17° 7 м/с -26° 5 м/с Үүлшинэ	I.16 -19° 6 м/с -26° 4 м/с Бага зэргийн цас орно	I.17 -18° 6 м/с -25° 4 м/с Үүлшинэ
---	---	---	---	---



ЗГМ: КОМИКС



ГАЛТ ТЭРЭГНИЙ ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-Москва	13:50	14:28
Эрэн-УБ	18:00	11:15
УБ-Бээжин	07:15	14:04
Хөх хот-УБ	22:50	11:15
УБ-Хөх хот	20:00	20:49
Эрхүү-УБ	15:35	06:20
УБ-Эрхүү	21:10	02:40
Замын-Үүд-УБ	21:35	09:55
УБ-Замын-Үүд	20:00	07:50
Эрдэнэт-УБ	19:10	05:48
УБ-Эрдэнэт	20:30	07:45

НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-Бээжин	08:00	11:50
Бээжин-УБ	17:15	19:30
УБ-Бишкек	11:25	13:55
Бишкек-УБ	04:30	11:30
УБ-Эрхүү	14:20	16:00
Эрхүү-УБ	16:45	18:10
УБ-Сөүл	17:10	21:15
Сөүл-УБ	13:00	15:50
УБ-Москва	08:20	10:10
Москва-УБ	00:00	07:10
УБ-Хонг Конг	07:51	12:25

Вальс намынхаа төлөө бодлогоо өөрчлөв

Социалист нам сонгуульд ялагдвал ноён Меланшон, Макрон хоёрын аль нэгтэй эвсэхээс аргагүй. > 10

Трампын анхааруулга эм үйлдвэрлэгчдийг цочоолоо

“Бид эмийн бүтээгдэхүүний гол худалдан авагч мөртлөө үнийг нь тогтоож чадахгүй юм” хэмээн Трамп мэдэгдлээ. > 10

Норвеги FM радио нэвтрүүлгийг халж эхэллээ

Аналог хэрэглээтэй норвегчууд тавхан FM радио сонсдог бол дижитал нэвтрүүлэгт шилжсэнээр 25 суваг сонсоно. > 10

Трамп хэвлэл, тагнуулынхныг шүүмжлэв

1 Тагнуулынхан Трампыг гадаад орны дэмжлэгтэй сонгогдсон мэтээр нотлохыг оролдож буй нь хэдийн тэдний харилцааг хурцатгаад байгаа билээ. Сөргөлдөх хандлагыг үл харгалзан ноён Трамп сонгуулийн үед Москва Ардчилсан намын үндэсний хорооны компьютерийг хакердаж, Хиллари Клинтоны сурталчилгаанд хохиролтой мэдээлэл цацсаныг хүлээн зөвшөөрчээ. “Миний бодлоор оросууд хийсэн байх. Гэвч биднийг бусад орон,

хүмүүс бас хакердаж байгаа” хэмээв. Ноён Трамп түүнчлэн өөрийнх нь олон улсын бизнес ашиг сонирхол Ерөнхийлөгчийн албан тушаалтай нь зөрчилдөг тухай шүүмжлэлийг намжаахыг оролдсон байна. Шилжилтийн үед түүний гадаад дахь үйл ажиллагаа гаднын дэглэмүүдтэй нягт холбоотой талаар мэдээ гарч байсан юм. Трампын талд ажилладаг татварын хуульч Шери Диллон хэвлэлийн бага хурал дээр сонгогдсон Ерөнхийлөгч өөрийн хөрөнгийг бусдад шилжүүлэх

АНУ-ын шинээр сонгогдсон Ерөнхийлөгч “Хэрвээ Путин Дональд Трампыг дэмжиж байгаа бол би үүнийг давуу тал гэж үзнэ. Харин үүрэг хариуцлага бус” гэжээ.



BVM©

Найдваргүй зээлийн эздийг илчлэх маргаан



Жеймс Полити

Италийн төдийгүй дэлхийд хамгийн эртнийхэд тооцогддог Monte dei Paschi di Siena (MPS) банкинд улсаас 6.5 тэрбум еврогийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэхдээ найдваргүй зээлүүдийнхээ эх сурвалжийг илчлэх шаардлага тавьж магадгүй байна. Италийн улстөрчид MPS банкинд хандаж, тайлан тэнцэл, зээлдэгчийн жагсаалтаа гаргаж өгөхийг шаардах, эсэх талаар хэлэлцэж байгаа аж. Хэрвээ ийм шийдвэр батлагдвал Европын банкны системд үл төлөгчдийг “нэрлэж

шившиглэсэн” анхны тохиолдол буюу банкны үйлчлүүлэгчдийн нууцыг хадгалах дүрэм, журмаас гажсан хэрэг болно. Дэлхийн хамгийн эртний бөгөөд Италийн гурав дахь том энэ банкинд үзүүлэх улс төрийн дарамт шахалт нэмэгдэж байгаа нь тус банк өнгөрсөн сард 8.8 тэрбум еврогийн капиталын дутагдалд орсноо хүлээж, улсаас мөнгө хүссэнээс үүджээ. Парламент дэх сөрөг хүчний гишүүд буюу Таван од хөдөлгөөн, Умардын холбоо намууд болон баруун төвийн Италийн хүч намынхан эрх

баригч Ардчилсан намд цохилт өгөх боломж гэж үзэж байгаа бололтой. Сөрөг хүчин зүүн төвийн улстөрчид, бизнесийнхэн MPS банктэй нягт холбоотойг үүгээр далимдуулан илчлэх зорилго тавьжээ. Сүүлийн өдрүүдэд Ерөнхий сайд асан Маттео Ренцийн тэргүүлдэг Ардчилсан нам хүртэл дээрх саналыг далдуур дэмжиж, Италид олон жил үргэлжилсэн банкны өр, зээлийн хямралын учир шалтгааныг тодруулах санаатай байж магадгүй гэж ажиглагчид тэмдэглэв. Ардчилсан намаас парламентад

Сангийн сайд Пиер Баретта MPS банкиг дампуурахад хүргэсэн нэгжүүдийн жагсаалтыг ил болгох нь ёс суртахууны хувьд зөв алхам гэжээ.

суугаа гишүүд Италийн банкны асуудлыг судалж буй тусгай комисс хямралд нөлөөлсөн үл төлөлтийн шалтгаанд дүн шинжилгээ хийх ёстой хэмээн ярьсан байна.

Италийн Сенат дахь санхүүгийн хорооны гишүүн Ардчилсан намын хууль тогтоогч Мауро Марино Financial Times сонинд ярихдаа “Ил тод байдал руу хийж буй алхам бүр нь дэмжүүштэй санаачилга мөн. Энэ асуудал маш их анхаарал татаж байгаа. Гэвч дагах ёстой журам байдаг тул бид үр дагаврыг нь тооцох хэрэгтэй. Иймээс яаж хэрэгжүүлэхээ бодож, зөв аргаар хийх нь зүйтэй” гэжээ. Өнгөрсөн сард Италийн Засгийн газар MPS болон бусад жижиг банкуудыг дэмжихэд зориулж, 20 тэрбум еврогийн санхүүжилт гаргаар шийдвэрлэсэн. Гэтэл санхүүгийн салбарт уг дэмжлэгийн талаар санал зөрөлдөөн үүсчээ.

Италийн Банкны холбооны ерөнхийлөгч Антонио Патүэлли орон нутгийн сонинд өгсөн ярилцлагадаа “Төлөгдөхгүй байгаа зээлийн эздийг нэрлэсэнээр банкнд худал мэдээлэл өгч зээл авсан үйлчлүүлэгчдийг илрүүлж, Италийн

банкны тогтолцоонд ил тод байдал авчирна” гэжээ. Харин нэгэн банкны удирдах ажилтан “Энэ бол солиорол. Эцэстээ нэр төртэй үйлчлүүлэгчид MPS-ээс нүүр буруулна. Популизм юунд хүргэхийн илрэл” хэмээн анхааруулав.

Италийн Банк, даатгал, санхүүгийн холбоо гэдэг хүчирхэг лобби бүлэг энэ саналд тайлбар өгөхөөс татгалзсан юм. Сангийн сайд Пиер Паоло Баретта тус банкныг дампуурахад хүргэсэн нэгжүүдийн жагсаалтыг ил болгох нь ёс суртахууны хувьд зөв алхам гэсэн боловч “Уг санаачилгыг хэрэгжүүлэхэд хялбар бус” гэж болгоомжилж байна. Миланы их сургуулийн профессор Карло Алберто Карневале дээрх санааг учир утгагүй зүйл гээд “Ингэж олон нийтэд зарлах нь ёс суртахууны суурь зарчмын эсрэг явдал. Хүндэтгэл хүлээдэг ямар ч бизнесэн нууц хадгалах хариуцлагаа биелүүлдэггүй банктэй хамтран ажиллахыг хүсэхгүй” хэмээн өгүүлэв. MPS банкны төлөөлөгч “Шаардлагатай бол жагсаалтыг нийтэлнэ. Гэхдээ одоо хуулиар зөвшөөрөгдөөгүй байна” гэж мэдэгджээ.



буюу бусдаар удирдуулахгүй гэдгийг тэмдэглэжээ. Үүний оронд Трампын бизнесийг хүүхдүүд нь удирдаж явуулах боловч гадаадын орнуудтай шинэ гэрээ хэлцэл байгуулахгүй гэж тохиролцсон аж. Тэрбээр твиттертээ “АНУ-ын тагнуулынхан түүнд сүүлийн нэг цохилт хийлээ” гэж бичжээ. Уг мэдээг тагнуулынхан нотолж чадаагүй ч улстөрчид болон хэвлэлийнхний дунд яригдсаар ирсэн агаад Financial Times сонин мөн үүнийг мэдэж байсан. Ноён Трамп нууц гэгдэх баримтыг нийтэлсэн хэвлэлүүдийг ярихдаа дээрх баримт гэгчид дурдсанчлан манайд Трампын нэр хүндэд харш ямар нэг баримт байхгүй хэмээн мэдэгдэв.

Ерөнхийлөгч Владимир Путин сонгуулийг хакердах тушаалыг биечлэн өгсөн, эсэх асуултад ноён Трамп “Тэр ийм зүйл хийх ёсгүй. Намайг Ерөнхийлөгч болсны дараа Орос улс АНУ-ыг илүү хүндэтгэн үздэг болно. Хэрвээ Путин Дональд Трампыг дэмжиж байгаа бол би үүнийг давуу тал гэж үзнэ. Харин үүрэг хариуцлага бус” гэжээ.

Төсөв хэмнэхийн тулд төслүүдийг танана

Симеон Керр

Саудын Араб 2020 он гэхэд төсвөө тэнцвэржүүлж, алдагдлаа багасгахын тулд олон тэрбум ам.долларын өртөгтэй төслүүдээ цуцлах арга хэмжээ авч эхэллээ. Газрын тосны үнэ унасны улмаас зардлаа танахад хүрсэн Засгийн газар PwC хэмээх зөвлөх фирмийг хөлслөн 13-20 тэрбум ам.долларын хэмнэлт хийх боломжийг судлах даалгавар өгсөн гэж албаны хүмүүс ярьжээ. Хэмнэлтийн гол нь капитал зардал болон дэд бүтцийн төслүүдэд хамаарна. Мөн Эр Рияд улс төрийн хувьд эмзэг нийгмийн зардлаас хасахаар зайлсхийхийг эрмэлзэж байгаа аж. Өнгөрсөн онд хэмнэлтийн арга хэмжээг эсэргүүцсэн жагсаал цуглаан болсон нь үүнд нөлөөлжээ.

Уг гэрээг мэдэх нэгэн бизнесмэний хэлснээр “PwC том тоонуудыг шалгаж, нарийн тооцоо хийхийн хамт яамдын санхүүгийн үүргийг нягтална. Аль нь юу хийж байгаа, хаана амархан таналт хийж болохыг

олох ёстой” гэнэ. Гэвч Засгийн газар болон PwC фирм уг асуудлаар тайлбар өгөхөөс татгалзав. Төслүүдийг эргэн судлах ажилд тээвэр, эрүүл мэнд, орон нутгийн үйлчилгээг хамруулах юм байна. Энэ нь 2014 онд нефтийн үнэ унаснаас хойш бүсээ чангалах бодлого барьж эхэлсний улмаас санхүүгийн дутагдалд орсон Саудын Арабын барилга болон бусад бизнест дахин нэрмээс болох төлөвтэй байна. Тус улсад төсвийн алдагдал 2015 онд 366 тэрбум риал байсан бол өнгөрсөн жил 297 тэрбум болтол бууруулж чадсан юм. Газрын тосны орлогоос санхүүжүүлж байсан улсын зардал Саудын эдийн засгийн өсөлтийн гол түлхэц болж байв. Гэвч Засгийн газар сүүлийн хоёр жил олон төслийг зогсоож, бас хойшлуулсан юм. Үүний улмаас компаниудад олгох төлбөрүүд тасалдаж, хувийн салбарт асуудал үүссэний дээр нефтийн бус салбарын өсөлт өнгөрсөн онд нэг хүрэхгүй хувь руу унаж,

Саудын барилгын томоохон компаниуд дотоод, гадаадын банкуудад хэдэн арван тэрбум ам.долларын өртэй.



олон жилийн доод үзүүлэлт боллоо. Сангийн яам хоёрдугаар сард 105 тэрбум риалын төлбөр эцэслэхээ амлажээ. Саудын Арабт гол шийдвэрийг гаргадаг Эдийн засаг, хөгжлийн зөвлөл хэмээх хүчирхэг байгууллага энэ долоо хоногт гадагш чиглэсэн төлбөрийг ил болгохын тулд цахим платформ ажиллуулна гэжээ. Вангийн дараа орох эрх

мэдэлтэй Мохаммед бин Салман уг зөвлөлийг толгойлдог агаад тус улсыг нефтийн хамаарлаас гаргах том төлөвлөгөөг удирдаж буй гэж үздэг. Төрийн салбарт бараа үйлчилгээ нийлүүлсэн боловч төлбөрөө авч чадалгүй удтал хүлээсэн олон гэрээлэгч саяхнаас мөнгөө авч эхлэв. Гэвч зарим компани нэхэмжлэлийнхээ үнийг бууруулахад хүрсэн гэсэн

гомдол гаргажээ. Saudi Binladin, Saudi Oger зэрэг барилгын томоохон компаниуд дотоод, гадаадын банкуудад хэдэн арван тэрбум ам.долларын өртэй бөгөөд тохиолдсон бэрхшээлд санхүүгийн системийг буруутгасан байна. Саудын төсвийн хэмнэлт мөн нефтээр баялаг болонгийн орнуудад нөлөөлж, бүс нутгийн компаниуд цуцлагдсан буюу

хойшлогдсон төслүүдийн оронд өөр гэрээ авах боломжийг хайх болов. Өнгөрсөн онд булангийн орнуудад дэд бүтцийн төслийн гэрээлсэн өртгийн хэмжээ 2015 оныхоос 44 хувиар унаж 100 тэрбум ам.доллар болсныг Middle East Economic Digest сэтгүүл мэдээлэв. 2014 онд уг хэмжээ 186 тэрбум ам.доллар байсан билээ.





BBM©

Вальс намын бодлогоо өөрчлөв

Анн-Сильвейн Шассани

Аж үйлдвэрийн хот Клермон-Ферран дахь дүрвэгсдийн төвд Афган, Суданы дүрвэгсдтэй хамт сельфи татуулж буй Мануэль Вальс франц зочломтгой зангийн үлгэр боллоо. “Бид 66 саяулаа улс. Дүрвэгсдийг багтаах зай бидэнд бий” хэмээн хуучин Ерөнхий сайд мягмар гаргт тайлбарлав. Багдадаас ирсэн Иракын цэргийн албан хаагч асан Мохамедтай ярилцахдаа ноён Вальс франц хэл сайн сурсныг нь магтаж байлаа.

Италигай хиллэдэг хэсгээр дамжин Францад нэвтрэх зорилготой мянга мянган дүрвэгчийг торгоогч цагдаа нарыг дэмжиж буйгаа Франсуа Олландын засаг захиргаанд Ерөнхий сайдын алба хашиж байсан ноён Вальс саяхан мэдэгдсэн. Тэрбээр Засгийн газраас гарсныхаа дараахан, Францын Социалист намаас Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшихийн тулд дүрвэгсдэд хандах байр сууриа өөрчилжээ.

Хоёрхон долоо хоногийн дараа сонгуулийн эхний шатанд өрсөлдөх ноён Вальсийн хувьд тавдугаар сард болох сүүлчийн шатанд ялах боломж хомс. Хэрэгжүүлж байсан бизнесийг дэмжигч шинэчлэлээ нь болоод санал хуваагдсан Социалист намыг сонгуулиас шалтгаалан мөхөхөд хүргэхгүйн тулд ноён Вальс чадах бүхнээ хийж байна.

“Намаа задрахад хүргэж гүйгээр, сонгуулийн эхний шатанд ялах гэвэл ноён Вальс

социалистуудын баруун жигүүрээс аль болох хурдан зүүн жигүүрт шилжих хэрэгтэй” хэмээн санал асуулгын ViaVoice компанийн тэргүүн Франсуа Микс-Марти тайлбарлав. “Өөрийнх нь баримталдаг бодлоготой таарахгүй учраас ингэж шилжих нь хэцүү” хэмээн ноён Микс-Марти өгүүлсэн юм.

Шинэчлэлийг зарлиг гаргах замаар хэрэгжүүлж болдог Үндсэн хуулийн заалтаас залхсанаа ноён Вальс мэдэгдсэн нь хүмүүсийг гайхшруулсан хэрэг боллоо. Учир нь ноён Вальс Ерөнхий сайд байх үедээ парламентын самуунч олонхийн зөвшөөрөлгүйгээр зургаан ч удаа либерал шинэчлэлийн арга хэмжээ авсан удаатай. “Ойлгох ч арга алга” хэмээн уг мэдэгдэлтэй холбогдуулан Эрчим хүчний сайд Сеголен Руаяль ням гаргт Snap Chat-д бичжээ.

Эдүгээ 54 настай ноён Вальс Францын 35 цагтай ажлын долоо хоногийг илүү уян хатан өөрчилж, эд хөрөнгийн татварын тогтолцоонд шинэчлэл хийх төлөвлөгөөнөөсөө ч татгалзлаа. Чухамдаа эдгээр бодлого л түүнийг намын баруун жигүүр дэх социал-демократ шинэтгэгч болгож байсан юм.

Франсуа Олланд өрсөлдөхгүйгээ мэдэгдсэн тул Барселонад төрсөн улс төрч сонгуулийн эхний шатанд улстөрийн хүнд хүчир үзүүлбэр үзүүлэхээс аргагүй боллоо. Эдийн засаг, аюулгүй байдлын асуудалд баруун жигүүрийн үзэл баримтлалд

шилжсэн төвч зүүний үзэлт сонгогчидтой тохиролцсоны үндсэн дээр ноён Вальс нэгдүгээр сарын 22-нд болох сонгуулийн эхний шатанд ялж дөнгөнө хэмээн зарим нь үздэг. Гэтэл намын зүүн жигүүрийн үзэл баримтлагч Арно Монтебур түүнийг нэгдүгээр сарын 29-нд болох сонгуулийн эхний шатны сүүлийн тойрогт ялж болзошгүй гэсэн дүн хоёр ч судалгаагаар гарчээ.

Ноён Вальсын хувьд өөр нэг ноцтой өрсөлдөгч нь Бенуа Амон. Эрс зүүний үзэлтэй ноён Амон 32 цагтай ажлын өдрийг хэвээр үлдээж, иргэдийн суурь орлогыг дэмжихийн тулд аж үйлдвэрийн роботод татвар оноохыг шаарддаг. Социалист нам доотроо гуравдугаарт яваа ноён Амоны байр суурь бэхжсээр байгаа нь сүүлийн санал асуулгаар тодорхой болсон юм.

Ноён Вальс Францын засгийн эрхэнд тэмүүлэхээсээ илүүтэй Социалист намыг сүйрлээс аврах гээд байгааг Шинжлэх ухааны судалгааны үндэсний төвийн (CNRS) профессор Люк Рубан тайлбарлав. Дөрөвдүгээр сарын 23-нд төгсөх Ерөнхийлөгчийн сонгуулийн эхний шатанд ноён Вальс сонгогчдын 10 орчим хувийн санал авахаар байгааг судалгаа харуулсан. Ингэж чадвал тэрбээр хэт зүүний хүчнээс нэр дэвшигч Жан-Люк Меланшон, бие даан өрсөлдөгч, Эдийн засгийн сайд асан Эммануэль Макрон нарын дараа буюу өрсөлдөгчдийн жагсаалтад тавдугаарт орно.

Харин төвч барууны хүчнээс нэр дэвшигч Франсуа Фийон, хэт барууны хүчний удирдагч Марин Ле Пен нар тавдугаар сарын 7-нд болох сонгуулийн эцсийн шатанд хүч үзэх төлөвтэй. “Ерөнхийлөгчийн сонгуулиас хойш Социалист намд хийх юм үгүй болно. Вальсийг Макрон баруун талаас нь, Меланшон зүүн талаас нь шахна. Энэ хүнд хөдлөө ч гэсэн зай үлдэхгүй” хэмээн ноён Рубан тайлбарлав.

Социалист нам сонгуульд ялагдах тохиолдолд ноён Меланшон, Макрон хоёрын аль нэгтэй эвсэхээс аргагүй хэмээн ноён Вальсад ойр дотно эх сурвалж таамаглаж байна. Ноён Олландын нэр хүндээ алдаж гүйцсэн засаглал, орон нутгийн сонгуулийн ялагдлын дараа чөлөөт зах зээлийг дэмжигчид, марксист арга баримтлагчдыг цаашид хамт ажиллуулах аргагүй болсон хэмээн тус намын гишүүн өгүүлсэн юм. “Франсуа Миттеран 1981 онд коммунистуудтай хамтран хэрэгжүүлсэн хөтөлбөрөөс хойш Социалист нам Францын зүүний хүчний төв болж байсан үе ийнхүү дууслаа” хэмээн дээрх гишүүн тайлбарлав.

Клермон-Ферраны ногоон технологийн компани, настныг асрах газраар зочилсныхоо дараа ноён Вальс спортын танхимд 300 дэмжигчийнхээ өмнө үг хэлсэн. Уг явдлаас хойш гуравхан хоноод мөн хотод ноён Макроны зохион байгуулсан цуглаанд 2500 дэмжигч цугласан юм.

FT

Норвеги FM радио нэвтрүүлгийг халж эхэллээ

Ричард Милне

Норвег лхагва гарагаас FM радио нэвтрүүлгээ зогсоож, бүрэн дижитал дамжуулалтад шилжиж эхэлсэн нь дотоодод маргаан дэгдээж, гаднын улс орнуудын сонирхол татсан үйл явдал боллоо. Умард Норвегийн Бодо хотод орон нутгийн цагаар 11.11 цагт эхэлсэн FM радио нэвтрүүлэг зогсоох ажиллагаа нийт улсын хэмжээнд энэ жилийн турш үргэлжилнэ.

Норвегид хэрэгжүүлж эхэлсэн арга хэмжээг Их Британи, Швейцарь, Дани зэрэг улс анхааралтай ажиглаж байна. Эдгээр улс энэ арван жилийн эцэс гэхэд ижил арга хэмжээ авахаар төлөвлөж байгаа юм. “Бүх улс Норвегоос үлгэр жишээ авахаар ажиглаж байгаа. Анхаарах ёстой нэг зүйл бол FM нэвтрүүлгийг зогсоохоос өмнө иргэдэд хугацаа гаргаж өгөх явдал. Бусад улсын төлөвлөж байгаатай харьцуулахад Норвег асуудлыг шуурхай шийдлээ” хэмээн Европын өргөн нэвтрүүлгийн холбооны (EBU) ахлах шинжээч Дэвид Фернадес-Кихада тайлбарлав.

Эрх баригчдын шийдвэрийг норвегчуудын ихэнх нь дэмжжээгүй. Тус улсын иргэдийн гуравны хоёр нь уг шийдвэрийг эсэргүүцсэн бол дөнгөж 17 хувь нь FM нэвтрүүлгийг зогсоосон нь зөв хэмээн үзсэнийг Dagbladet сонинноос явуулсан санал асуулга харууллаа. Ялангуяа автомашинууд болон онцгой байдлын холбоонд дижитал DAB хүлээн авагч цөөн хэвээр байгааг шүүмжлэгчид анхааруулж байна.

“Автомашин татвар өндөр, дээр нь хуучин автомашин ихтэй Норвегид ийм шилжилт түвэгтэй. Хүмүүс радио нэвтрүүлгэд мөнгө төлж сураагүй учраас эсэргүүцэх нь их байгаа” хэмээн Ослогийн их сургуулийн профессор Сьерре Хольм өгүүлсэн юм. Фьорд бүхий уулархаг Норвег улсад аналог FM-ийг дижитал

радио нэвтрүүлэгтэй зэрэгцүүлэн дэмжиж явах нь өндөр өртөгтэй тусдаг. Гэтэл DAB нэвтрүүлгийн чанар FM-ээс илүү сайн. Эдүгээ норвегчуудын 75 хувь нь дижитал радио сонсох нөхцөлөөр хангагдаад байгаа. Гэвч бараг хоёр сая автомашин DAB төхөөрөмжгүй хэвээр. Дижитал нэвтрүүлгийг хувиргагч адаптер тус улсад 1000-2000 норвег крон буюу 115-230 ам.долларын үнэтэй.

Аналог телевизийн нэвтрүүлгийг зогсооход дамжуулах давтамжийн хүрээг нь мобайл болон өргөн зурвасын нэвтрүүлгийн хэрэглээнд шинэчлэн хуваарилсан. Харин FM радио нэвтрүүлгийн давтамжийн хүрээг өөр хэрэглээнд ашиглах сонголт одоогоор байхгүй. “Эдийн засгийн үүднээс авч үзвэл FM-ээс уйдах цаг арай ч болоогүй” хэмээн ноён Фернадес-Кихада тайлбарлав.

Бүх FM радио нэвтрүүлгийг Норвег даяар шууд зогсоохгүй. Эхний ээлжинд зөвхөн төр, олон нийтийн мэдлийн радио станцууд нэвтрүүлгээ зогсоох юм. Орон нутгийн FM радио компаниуд цаашид ч аналог дамжуулалттай нэвтрүүлгээ хэвээр үргэлжлүүлнэ. Дижитал дамжуулалтад шилжсэнээр норвегчуудын хүлээн авах сувгийн тоо эрс өсөж байна. Аналог хэрэглээтэй норвегчууд тавхан FM радио сондог бол дижитал нэвтрүүлэгт шилжсэнээр 25 суваг хүлээн авах боломжтой.

Норвег улс урт болон дунд долгионы радио дамжуулагчийн хэрэглээг бүр өмнө халсан нь FM-ээс дижитал өргөн нэвтрүүлэгт шилжих явцыг хялбарчилж өглөө. Гэхдээ телевиз зээгчтэй харьцуулахад радио нэвтрүүлэг сонсогчид тодорхой сувагт илүү үнэнч байдаг. Энэ нь иргэдийн дунд дургүйцэл үүсэхэд хүргэж болзошгүйг тус улсад явуулсан судалгаа харуулж байна.

FT



BBM©

Трампын анхааруулга эм үйлдвэрлэгчдийг цочоолоо

Барни Жолсон

Өөрийнх нь Засгийн газар эмийн үнийг бууруулахын төлөө тэмцэх тухай Дональд Трамп гэнэт мэдэгдсэн нь эм үйлдвэрлэгчдийг цочоосон хэрэг боллоо. АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд ялсанаасаа хойш анх удаа хийж буй хэвлэлийн хурал дээр ноён Трамп эмийн компаниудыг ширүүн шүүмжиллээ. Тэрбээр эм үйлдвэрлэгчид бүтээгдэхүүнийхээ төлбөрт хэт ихийг шаарддаг нь “Хүн алаад зугтсан”-тай адил хэмээн зүйрлэсэн юм.

АНУ-ын Ерөнхийлөгчөөр сонгогдогчийн Twitter-тээ бичдэг товч тайлбарууд нь Johnson & Johnson, Pfizer зэрэг эмийн компаниудын хувьцааны үнийг унагаж, автомашин үйлдвэрлэл зэрэг чухал салбарыг бүхэлд нь доргиосоор. “Бид дэлхийд эмийн бүтээгдэхүүний гол худалдан авагч атлаа үнийг нь тогтоож



BBM©

чадахгүй юм” хэмээн ноён Трамп Нью-Йоркод болсон хэвлэлийн хурал дээр мэдэгдлээ. Ядуус, настнуудад зориулсан

Medicare, Medicaid хэмээх олон тэрбум ам.долларын өртөгтэй эрүүл мэндийн хөтөлбөрийн хүрээнд АНУ-ын Засгийн

газар нь эмийн бүтээгдэхүүний аварга худалдан авагч болдог. Гэтэл АНУ-ын засаг захиргаа эрх мэдлээ хэрэгжүүлэхэд нь

эм үйлдвэрлэгчид саад тотгор учруулж, удаашруулсаар өдий хүрлээ. “Хэрвээ би эмийн компанийн захирал байгаад АНУ-ын Ерөнхийлөгчөөс ийм үг сонсвол бушуухан зүрхний эмээ л шүүрнэ” хэмээн Клинтонь засаг захиргаанд ахлах эдийн засагч байсан, эрүүлийг хамгаалахын шинжээч Жо Миннарик өгүүллээ.

Цагаан ордон мөн үгнээ “шударга бус”-аар өсгөсөн компаниудыг торгох эрхийг зохицуулагчдад олгож, эмийн бусад хувилбар боловсруулахыг дэмжих замаар хувийн зах зээл дээрх үнэд нөлөөлөх боломжтой. Дээрх хоёр санаачилгыг Ардчилсан намаас Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөөд ялагдсан Хиллари Клинтон компанийнхаа үеэр дэвшүүлж байсан юм.

NASDAQ-ийн биотехнологийн индекс жин үд болох үед 3.7 хувиар унасан нь 2017 онд 5.2-оор

өссөн ашгаасаа эргүүлж алдсан хэрэг боллоо. Эм үйлдвэрлэгч том компаниудын хувьцааны үнэ ч буурав. АНУ-ын эмийн бүтээгдэхүүний манлайлагч групп Johnson & Johnson-ийнх нэг хувиар, өрсөлдөгч Pfizer-ийнх 2.2 хувиар тус тус унав.

Эрүүлийг хамгаалах салбарт хийх Obamascare шинэчлэлийг санхүүжүүлэхэд зориулан ирэх 10 жилд 80 тэрбум ам.доллар зориулахаар эм үйлдвэрлэгчид 2009 онд Цагаан ордонтой тохиролцсон. Энэ нь Medicare хөтөлбөрт хамрагдаж буй хүмүүст эмийн үнийг нь тогтоож өгөх төлөвлөгөөнөөсөө Засгийн газар татгалзсаны хариуд эм үйлдвэрлэгчдээ өгч буй бэлэг юм. Харин Ерөнхийлөгч Барак Обамагийн амжилт бүтээлийн нэг Obamascare-ийг цуцлахаа ноён Трамп амлаад байгаа.

FT

Эдийн засаг

ОРОН СУУЦ

◀1

Энэ бол 2014 он. Үүнээс хойш үнэ болон индекс тасралтгүй уруудав. Жилийн өмнө 1.8 сая төгрөг байсан “Аман хуур” хотхоны нэг ам метр талбай өдгөө 1.7 саяд хүрчээ. Уншигч та 2013 оноос 2016 он хүртэлх орон сууцны үнийн индексийн уул шиг дүртэй муруйг анзаарч нэг тогтоорой. Өнгөрсөн гурван жилийн хугацаанд орон сууцны зах зээлд өрнөсөн үйл явдлыг энэ графикаас тодорхой харж болно. Оргил өөд тэмүүлж байсан индекс эргэн газардаж буй нь энэ.

Арванхоёрдугаар сард ч мөн орон сууцны үнийн индекс буурлаа. Гэхдээ зогсолтгүй уруудаж байсан чөлөөт уналт нь саарчээ. Индекс арваннэгдүгээр сараас 0.1 хувиар буурсан. 2015 оны сүүлийн сараас 4.3 хувиар багасчээ. Ялангуяа шинэ орон сууцны индексийн уналт бараг зогсох дөхсөн байна. Өнгөрсөн

Орон сууцны зах зээлд сүүлийн 5-6 жил ажиглагдаагүй хамгийн таатай үе ирж байна.



С.Батсайхан / ЗГМӨ

ЗГМ ТОВЧХОН

» ҮНЭТ ЦААС

2.5

Хувь. Засгийн газрын нэг сая төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий хоёр жилийн хугацаатай 2.5 тэрбум төгрөгийн 18 хувийн купонтой бондыг арилжлаа. Жигнэсэн дундаж хүү нь 18 хувь байв.

» УУЛ УУРХАЙ

87.4

Хувь. Өнгөрсөн оны арваннэгдүгээр сарын байдлаар газрын тосны орлогын биелэлт 87.4 хувьд хүрснийг Ашигт малтмал, газрын тосны газраас мэдээлэв.

» ТЕХНОЛОГИ

1.5

Хувь. Олон улсын зах зээлд суурин болон зөөврийн компьютерийн нийлүүлэлт өнгөрсөн улиралд 1.5 хувиар буурчээ. IDC байгууллагын мэдээлснээр үйлдвэрлэгчид өнгөрсөн онд олон улсад 70.2 сая орчим компьютер нийлүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 1.1 саяар буурсан дүн.

» ХӨРШ

1.7

Их наяд. БНХАУ бүтээн байгуулалтын 1.7 их наяд юунаар хэмжигдэх 227 төсөлд хэрэгжүүлжээ.

» ДЭЛХИЙД

1.4

Их наяд иен. Японы урсгал дансны ашиг арваннэгдүгээр сард 1.4 их наяд иенд хүрчээ.

8

Хувь. “Airbus” компанийн нийлүүлэлт 2016 онд найман хувиар өссөн байна.

1.14

Тэрбум евро. Франц улсын Засгийн газар “Engie” компанийн 4.1 хувийг худалдаж, 1.14 тэрбум еврогийн хөрөнгө босгов.

28

Тэрбум ам.доллар. “Johnson & Johnson” компани Швейцарийн биотехнологийн “Actelion” компанийг худалдаж авахаар урьдчилсан тохиролцоо хийжээ. Ойрын эх сурвалжийн мэдээлснээр “Johnson & Johnson” компани “Actelion”-ийн нэгж хувьцааг 260 ам.доллараар үнэлж, 28 тэрбумоор авах санал тавьжээ.

» САНХҮҮГИЙН ТОЛЬ

Хэвийн бус өгөөж (Anomalies) Хүлээгдэж буй болон бодит өгөөжийн зөрүү. Өөрөөр хэлбэл, зах зээл үр ашигтай буюу олон нийтэд байгаа мэдээлэл нь хувьцааны үнэд бүрэн туссан л бол хөрөнгө оруулагчдын таамаглаж буй өгөөж гажих ёсгүй юм.


ВАЛЮТЫН ХАНШ

АНУ доллар	2497.04
Евро	2654.35
Япон иен	21.84
ОХУ рубль	42.01
БНХАУ юань	361.37
БНСУ вон	2.12

Хөөс замхарч, хөрсөнд бууж буй үнэ

сарын үзүүлэлтийг 2015 оны мөн үетэй харьцуулахад 0.02 хувиар доошилсон. Харин хуучин сууцны үнийн индекс эсрэгээрээ тууштай багасаж байна. Жилийн өмнөхөөс бараг 12 хувиар багасчихаж.

Төв банкны захиалгаар “Тэнхлэг зууч” компанийн тооцдог энэ индексийг орон сууцны үнэ гээд шууд хэлчихэж болохгүй. Гэхдээ зах зээл дэх 5047 орон сууцны үнийг жигнэн тооцдог гэдэг утгаараа уг индекс үнийн өөрчлөлтийг яалт ч үгүй илэрхийлнэ. Тиймээс орон сууцны үнэ дунджаар төдий хувиар буурсан гэж үзэхэд болно. Жилийн өмнө 80 сая төгрөгийн үнэ хүрч байсан хоёр өрөө хуучин байр дунджаар 74 сая болоод



байгаа ажээ.

Харин одоо ганц асуулт. Орон сууцны үнийн индексийн уналт бараг 30 сар үргэлжилж байгаа. Энэ чөлөөт уналт орон сууцны

бодит үнэд нөлөөлж, үл хөдлөх хөрөнгө үнэ цэнээ алдахад хүрсэн үү. Өнгөрсөн сарын байдлаар орон сууцны индекс 1009 нэгжид хүрээд байгааг дээр

өгүүлсэн. Энэ нь орон сууцны үнэ хөөрөхөөс өмнө буюу эхний индексээс багаар бодоход 0.9 нэгжээр өндөр байна. Өөрөөр хэлбэл, үнийн үсрэлтээс өмнөх үетэй харьцуулахад өнөөгийн ханш өндөр байна гэсэн үг.

Үнийн индексийн уналт бараг 30 сар үргэлжилж байна

Орон сууцны үнийн индекс болон ханш аль аль нь буурч

байгаа нь үнэн. Гэхдээ энэ нь орон сууцны бодит үнэ буурч, үнэ цэнээ алдаж буй хэрэг биш. Харин эрэлтэд дөрөөлөн хөөсөрсөн үнэ эргэн хөрсөндөө бууж буй нь энэ. Төв банкнаас танилцуулдаг индексийг харвал орон сууцны үнэ ахиад ч буурах төлөвтэй. Ингэж байж бодит үнэ тогтох нь.

Харин сайн мэдээ нь эрүүл үнэ тогтоход ойрхон байна. Тэр утгаар үнийн эрчимтэй уналт одоо тогтворжиж эхэлснийг “Тэнхлэг зууч” компанийн гүйцэтгэх захирал Д.Должинсүрэн мэдээлэв. Харин үүнээс худалдан авагч та ашиг хүртэх нь. Хэрэв та орон сууц худалдан авахаар зэхэж буй сүүлийн 5-6 жил ажиглагдаагүй хамгийн таатай үе ирж байна. [ЗГМ]

ӨДӨР БҮР ДРАКЕРТАЙ ХАМТ

Хуучныг орхих чадвар

Өнгөрснийг орхиж чадахгүй бол маргаашийг бүтээж чадахгүй



“Өдөр бүр Дракертай хамт” номноос “Хуучныг орхих хэцүү” хэсгийг онцлолоо. Зөв зүйлийг хийх урам зориг, шинэ санаа өгөх 366 өдрийн хичээлийн эхний хичээлд танд ийн хурч байна. “Өдөр бүр Дракертай хамт” ном нь Питэр Ф.Дракерын бүтээлүүдийн гол санаануудыг багтаан хураангуйлан гаргасан бүтээл юм. Үр бүтээлтэй захирлын ширээний ном болох энэхүү бүтээл нь гүйцэтгэлд чиглэсэн болохыг Питэр Ф.Дракер тодотгосон удаатай. Тэрбээр “Сайнаас азуу руу” номын зохиолч Жим Коллинз-д “Өөрийгөө дайчилж хүмүүст тустай нэгэн бол” гэж хэлсэн тухай Жим Коллинз хожим нь өгүүлсэн байдаг. Питэр Ф.Дракер нь менежментийн ухааныг үндэслэгч бөгөөд XX зууны сүүлийн хагасын менежментийн хамгийн нөлөө бүхий сэтгэгчдийн нэг юм.

Бүтээлч удирдах албан тушаалтнууд олон зүйлийг үр бүтээлтэйгээр хийх ёстой гэдгийг мэддэг. Тиймээс ч тэд төвлөрч чаддаг. Удирдах албан тушаалтны анхаарлаа хандуулах эхний ажил бол ашиг өгөхөө больсон өнгөрсөн үеэс салах явдал юм. Ховор бөгөөд хамгийн чанартай баялаг болох хүний хөдөлмөрийн хүчээ шууд л маргаашийн боломжуудын төлөө ажиллуулж эхлэх хэрэгтэй. Хэрвээ удирдагчид өнгөрснийг орхиж чадахгүй бол маргаашийг бүтээж чадахгүй.

Зохион байгуулалттай, зорилтгойгоор хуучныг орхиж чадахгүй бол байгууллага сүйрэлд хүрнэ. Ингэснээр хамгийн чухал баялгаа хийх ёсгүй, хэрэгцээгүй болсон зүйлүүд дээр дэмий зарлагадах болно. Улмаар гарч ирсэн боломжуудыг тултал нь ашиглаж байх үүрэгтэй гол баялаг болох чадварлаг хүмүүсээр дутагдана. Хуруу дарам цөөн байгууллага л өнгөрснөө орхих шийдвэр гаргахад бэлэн, маргааааааа бэлтгэсэн баялагтай байдаг.

Гүйцэтгэх зүйл: Урагшгүй болсон бизнест нөөц баялгаа үрэхээ зогсоож, оронд нь чадварлаг хүмүүстээ шинэ боломжуудыг ашиглах бололцоо олго.

“Өдөр бүр Дракертай хамт” номын талаар АПУ компанийн гүйцэтгэх захирал Ц.Эрдэнбилэг “Үйлдвэрийн менежмент үнэхээр амаргүй, нарийн түвэгтэй байдаг зүйл. Би анх компанийн, тэр тусмаа үйлдвэрийн үйл ажиллагааг удирдах арга зүйн талаар үйлдвэрийн ахмад удирдлага хамт олноос их зүйлийг сурч, ажил амьдралдаа хэрэгжүүлж үр дүнд нь ч мэдэрч байна. Залуучуудад болон бусдад, зөв оновчтойгоор сайн удирдах талаар өөрөөсөө илүү туршлагатай хүмүүсээс, шууд болон бүтээлүүдээс нь суралцах нь маш зүйтэй шүү хэмээн зөвлөө” хэмээн өгүүлсэн юм.

ХӨДӨӨ АЖ АХУЙ

Тооноос чанарт шилжинэ

Г.Илч
ЗГМ

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын удирдлагаар чуулж байгаа. Тэд 2016-2020 он хүртэлх зорилго, зорилтуудаа хэлэлцэж байна. Энэ үед Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн хариуцлага, хяналтыг эрхэмлэж

ЗАСАГ ДАРГА ЯРЬЖ БАЙНА

С.Гансэлэм: Бургастайн боомтыг зориулалтын дагуу өргөжүүлнэ

Б.Баяртогтох
@bayartogtokhZGM

Говь-Алтай аймгийн Засаг дарга С.Гансэлэмтэй ярилцлаа. “Эдийн засгийн сорилтыг төр, хувийн хэвшил хамтарч байж даван туулаа” хэмээн тэрбээр тодотгов.

-Аймгуудын өрсөлдөх чадварын үзүүлэлтээр Говь-Алтай аймаг 19 дүгээр байранд эрэмбэлэгдсэн. Уг судалгаагаар ажлын байрыг шинээр бий болгох, хүртээмжийг нь нэмэгдүүлэх шаардлага тулгарч байгаа. Тэгэхээр орон нутгийн удирдлагын зүгээс энэ байдлыг сайжруулахаар ямар бодлого, зорилтыг дэвшүүлж байна вэ?

-Орон нутгаа хөгжүүлэхийн тулд бусад аймагтай харьцуулах байдлаар хаана, ямар түвшинд яваагаа мэдэж, нөхцөл байдлаа хэмжиж үзэх нь чухал. Хэмжиж чадахгүй бол хянаж чадахгүй бол боловсронгуй болгож чадахгүй. Тиймээс өрсөлдөх чадвараа сайжруулах чиглэлд манай баг нэлээд анхаарал хандуулж, үүнд ихээхэн ач холбогдол өгч байгаа.

Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт өрсөлдөх чадвараа дээшлүүлэх хүрээнд цөөнгүй ажил тусгагдсан. Үүнийг ирэх жилүүдэд бодит ажил болгохоор зорьж байна. Аймаг болгон өөрсдийн гэсэн

ажиллахаа мэдэгдлээ.

Монгол Улсын Засгийн газраас эдийн засгийг сэргээж, олон улсын эдийн засгийн бүтцийг цогцлоохоор зорьж буй. Эдийн засгийг богино хугацаанд сэргээхэд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын үүрэг чухал болохыг салбарын сайд нь онцлов. Нийт ажиллах үйлдвэрийн сайд П.Сэргэлэн байраар хангадаг энэ салбарын

тогтвортой хөгжил улс орны хөгжлийн суурь болоод байгаа аж. Мөн Засгийн газар 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийнхөө үндэс болгожээ. Иймд үйлдвэрлэлийн бүтээмж, өрсөлдөх чадвар, үр ашгийг нэмэгдүүлэх, тооноос чанарт шилжихийг эрхэм зорилго болгож байна. Салбарын удирдах ажилтны зөвлөгөөнөөдөр хоёр дахь өдрөө үргэлжилнэ. [ЗГМ]

онцлогтой бөгөөд давуу болон сул талтай. Манай аймгийн хувьд эдийн засгийн тамир тэнхээ, дэд бүтэц гэсэн хоёр үзүүлэлтээр өнгөрсөн хугацаанд багагүй оноо алдаж ирсэн юм билээ. Тэгэхээр эдийн засгаа тэлэхийн зэрэгцээ дэд бүтцээ шинэ шатанд гаргах нь чухал байна. Эдийн засаг, төсвийн хүндрэлтэй нөхцөл байдлыг харгалзан хэмнэлтийн горимд ажиллаж байгаа. Уг ажлын хүрээнд төсвийн орлогыг нэмэгдүүлэх, урсгал зардлыг эдийн засаг, төсвийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх, сахилга харуцлагыг сайжруулах чиглэлээр багагүй ажлын ард гарлаа.

-Эдийн засгийн хүндрэлтэй байдал үргэлжилсэн хэвээр байна. Энэ нь та бүхний хийхээр төлөвлөж буй олон ажил саатах бодит шалтгааны нэг. Тиймээс зураглаж буй ажлууд цаасан дээр үлдэх эрсдэл бий. Үүнийг давхар тооцоолж байгаа юу?

-Эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал хаа сайгүй амаргүй байгааг эхэнд тэмдэглэсэн. Үүнийг алхам тутам тооцоод суунал ажил хийх хүн олдохгүй. Манай аймгийн хувьд өөрсдийн нөөц боломжоо ашиглах, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг орон нутагтаа татах чиглэлээр цаашид нэлээд санаачилгатай ажиллах сонирхолтой байгаа. Өөрөөр хэлбэл, төсвийн хөрөнгө оруулалтаар зогсохгүй бусад хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх чиглэлд нээлттэй бодлого

хэрэгжүүлнэ. Энэ нь төр, хувийн хэвшилийн хамтын ажиллагааг илүү эрчимжүүлэн гэсэн үг.

Хийе, бүтээе гэсэн сэтгэлтэй, тэмүүлэлтэй хувийн хэвшилээ түлхүү дэмжинэ. Ингэснээр үүсээд байгаа эдийн засгийн хүндрэлийг даван туулах боломжтой. Ажил хийх хүнд арга олддог. Энэ үг манай багийн бараг л зарчим болж байгаа. Зорьсон олон ажлын үр дүнд дээр дурдсан өрсөлдөх чадвар нийт дүнгээрээ сайжирна гэж үзэж байна.

-Аймаг болгон өөрсдийн хөгжлийн тулгуур салбараа тодорхойлж байна. Говь-Алтай аймгийн хувьд аль салбарт найдвар тавьж, илүү эрчимтэй хөгжүүлэхээр зорьж байна вэ?

-Манай аймгийн хувьд хөгжлийн тулгуур салбар нь хөдөө аж ахуй. Түүн дотроо мал аж ахуй болон газар тариалангийн салбар илүү байр суурь эзлэнэ. Цаашид түшиглэн хөгжих тулхуур хоёр гол салбар гэж эдгээрийг тодорхойлж байгаа. Эдгээр нь үндсэндээ уламжлалт салбар бөгөөд эдийн засгийн суурь бааз болж ирсэн. Тиймээс цаашид илүү дэвшил гаргах шаардлага бий. Ялангуяа газар тариалангийн салбарт түлхүү анхаарах хэрэгтэй байна. Учир нь өнгөрсөн хугацаанд тус салбарт чиглэсэн бодит хөрөнгө оруулалт, дорвитой төсөл хэрэгжсэн нь нэлээд ховор. Мал аж ахуйн салбарын хувьд хийх ажил ч мөн цөөнгүй бий.

Эдийн засаг

ЗАСАГ ДАРГА ЯРЬЖ БАЙНА

С.Гансэлэм: Бургастайн боомтыг зориулалтын дагуу өргөжүүлнэ

Шинээр хөгжүүлэхээр төлөвлөж буй салбарын нэг нь уул уурхай

◀11

Тухайлбал, малын үүлдэр, угсаагаа сайжруулах, малын гаралтай түүхий эд болон дайвар бүтээгдэхүүнийг боловсруулах, нэмүү өртөг шингээх замаар орлогын гол эх үүсвэрээ болгох үүд хаалга нээлттэй байна. Үүнийг ашиглах нь чухал. Мал аж ахуйн салбарын бүтээмжийг нэмэгдүүлж, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх цаг болсон. Шинээр хөгжүүлэхээр төлөвлөж буй салбарын нэг нь уул уурхай. Манай аймгийн хувьд уул уурхай болон аялал жуулчлалын салбар хожуу хөгжсөн. Аль аль нь эдийн засгийн хувьд үр ашигтай. Гэхдээ хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх ёстой. Үүнийг гол зарчмаа болгож, цаашид мөрдөж ажиллах юм.

-Уул уурхай нь эдийн засгийн өгөөж өндөртэй ч байгаль орчинд хал ихтэй. Гэхдээ хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж буй сайн жишээ цөөнгүй бий?

-Тийм ээ. Уул уурхайн салбарт эерэг болон сөрөг жишээ олон. Тэр болгоноос суралцах хэрэгцээ, шаардлага их гарч байна. Уул уурхайн салбарын талаарх орон нутгийн иргэдийн ойлголт харилцан адилгүй. Манай аймгийн хувьд "Алтайн хүдэр" компанийг эс тооцвол томоохон экспортын шинж чанартай уурхай байхгүй. Тус компанийн хувьд БНХАУ-д төмрийн хүдрээ экспортолдог. Түүхий эдийн үнэ огцом унаснаас үйл ажиллагаа нь зогссонги



Б.Ганбаяр / ЗГМ

байдалд ороод байсан. Гэхдээ зах зээлд үнийн бага зэрэг сэргэлт ажиглагдах болсон тул экспорт хийж эхэлсэн. "Алтайн хүдэр"-ийн үйл ажиллагаатай удахгүй газар дээр нь очиж танилцана.

-Уул уурхайг хөгжүүлнэ гэхээр шууд л олборлолт санаанд орох нь бий. Гэтэл эдийн засгийн үр ашигтай орд нээхийн тулд геологийн суурь судалгаанаас эхлээд хайгуулын олон шат дамжлагыг туулах шаардлагатай болдог. Үүнд маш их цаг хугацаа, хөрөнгө оруулалт зарцуулж, улмаар томоохон төсөл хэрэгжүүлэх хаалга нээгдэж ирсэн?

-Энэ жишгээр л уул уурхайн салбар хөгждөг. Геологи, хайгуулын суурь судалгааны ажил цаашид тодорхой хэмжээнд идэвхжиж, бүс нутгийн хөгжилд өөрчлөлт авчрах мега төсөл

хэрэгжүүлэх боломжийг улсаас бодлого болгож байна. Орон нутгийн зүгээс уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж болон бичил уурхай эрхлэгчдэд нийгмийн хариуцлагын гэрээнд Засаг даргын хувьд түлхүү ач холбогдол өгч, үүрэг, хариуцлагыг нь дээшлүүлэхээр төлөвлөж байна.

-Аялал жуулчлал хөгжих боломжтой бүс нутаг бол Говь-Алтай. Говь, хээр хосолсон байгалийн өвөрмөц тогтоотой. Ховор ан, амьтан ч нэлээд бий. Энэ болгон нь жуулчдын

харааг татах давуу тал. Та аялал жуулчлалын салбарыг онцолсон. Тус салбарыг хөгжүүлэхэд орон нутгийн зүгээс хэр дэмжлэг үзүүлж чадах вэ?

-“Утаагүй үйлдвэрлэл” хэмээн тодотгодог тус салбар манай нутагт хөгжих өргөн боломжтой. Гэхдээ дэд бүтцийн сул хөгжлөөс шалтгаалж зорьж очих гадаад, дотоодын жуулчдын тоо хязгаарлагдаж байгааг үгүйсгэхгүй. Аялал жуулчлалыг хөгжүүлэхийн тулд дэд бүтцээ нэн тэргүүнд сайжруулах шаардлагатай байгаа нь үнэн. Энэ хүрээнд цаашид ч ажиллах шаардлага их байна. Аялал жуулчлал хөгжихөд хувийн хэвшлийн үүрэг, оролцоо нэлээд чухал. Бидний зүгээс бодлогын түвшинд хувийн хэвшлээ дэмжиж ажиллана. Стандарт шаардлага хангасан жуулчны бааз, орон нутгийн онцлог шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох шаардлага гарч байна. Үүнд орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа хувийн хэвшил тэргүүлэх үүрэгтэй оролцох хэрэгтэй.

Алтайгаас Баян-хонгор хүртэлх 256 км авто замын ажлыг энэ хавар эхлүүлнэ

-Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах шаардлага тулгамдсан асуудлын нэг. Энэ хүрээнд ямар зарчим баримталж ажиллах вэ?

-Төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын гурван талт түншлэлийг бэхжүүлэх нь чухал. Ингэснээр төрийн үйл ажиллагааг ил тод нээлттэй болгох, иргэдийн дуу

хоолойг сонсох, төрийн зарим ажил үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх нь зөв. Эдийн засгийн сорилтыг төр, хувийн хэвшил хамтарч байж даван туулна. Үр дүнд нь иргэдийн амьжиргааны түвшин сайжрахын зэрэгцээ хувийн хэвшлийн оролцоо ч тэлэх юм.

-Орон нутгийн хэмжээнд шилжих хөдөлгөөн багассан уу, эсвэл хэвээр байгаа юу?

-Нутаг орондоо тогтвортой ажиллах хүсэл, сонирхолтой иргэдийн тоо эрс нэмэгдэж байна. Үүнийг дагаад ажлын байрны хүндрэл гарч байгааг үгүйсгэхгүй. Гэхдээ жижиг, дунд үйлдвэрлэл хөгжих замаар иргэдээ ажилтай, орлоготой байлгах гарц байгаа. Иргэдийн хандлага өөрчлөгдөж байгаагийн илрэл нь дээрх байдлаар харагдаж байгаа тул хувьдаа олзуурхаж сууна.

-Бургастайн боомтоор мах болон малын гаралтай түүхий эдийн экспортыг нэмэгдүүлэхэд хэр анхаарч ажиллах вэ. Энэ хүрээнд цаашид ямар ажил хийхээр төлөвлөж байгаа бол...?

-Бургастайн боомтын нөхцөл байдалтай танилцсан. Боомтын үйл ажиллагааг сайжруулах, цаашид анхаарах зүйл нэлээд байсан. Худалдаа, эдийн засгийн гүүр болох боомт гэж хэлэхэд чамлалтай санагдсан. Тус боомтоор "Алтайн хүдэр" компанийн төмрийн хүдэр гарч байгаа. Энэ нь боомтын хувьд өрөөсгөл. Тиймээс боомтыг зориулалтын дагуу ашиглах хүсэлтэй байгаагаа Хятадын талд илэрхийлсэн. Зөвхөн төмрийн хүдэр гаргах бус малын гаралтай түүхий эд, барилгын материалыг уг боомтоор нэвтрүүлэх нь чухал. Гол нь орон нутгийн иргэдэд ээлтэй, амьдралд нь ашиг тустай байх хэрэгтэй. Энэ байдлыг бий болгохоор зорьж байна. Бургастайн боомт нь тэгш саруудад нээгдэж байгаа. Манай

аймагтай хил залгаа Ховдод бог малын халдварт өвчин гарснаас мах болон малын гаралтай түүхий эдийн экспортод хориг тогтоосон. Үүнээс шалтгаалж зарим ажил саатсан.

-Махны үйлдвэр ашиглалтад орох гэж байгааг сонссон. Үйлдвэр ашиглалтад орсноор хэчнээн ажлын байр бий болох боломжтой вэ?

-Баруун бүсийн аймгуудаас махны үйлдвэргүй ганц аймаг нь манайх байсан. Өнгөрсөн зун махны гурван үйлдвэр шаваа тавьж, барилгын ажлаа эхлүүлсэн. Энэхүү үйлдвэр ашиглалтад орсноор хамгийн багадаа 50 орчим ажлын байр шинээр бий болж судалгаа бий. Үйлдвэртэй болсноор ажлын байр бий болоод зогсохгүй малчдын орлого нэмэгдэх, мал болон малын гаралтай түүхий эдийн үнэ тогтвортой байхад эерэг нөлөө үзүүлнэ.


-Нийслэлтэй хатуу хучилттай авто замаар холбогдоогүй аймгийн нэг нь Говь-Алтай. Одоо хэчнээн км авто замын ажил дутуу үлдсэн бэ?

-Алтайгаас Баянхонгор хүртэлх 256 км авто замын ажлыг энэ хавар эхлүүлнэ. Ингэснээр ирэх арваннэгдүгээр сар гэхэд ашиглалтад орчихно гэж харж байгаа. Энэ нь мөрийн хөтөлбөрийн дөрвөн чухал ажлын нэг.

-Улсын нэгдсэн төсвөөс гадна олон улсын дэмжлэгтэй төсөл, хөтөлбөр Говь-Алтайд хэр зэрэг хэрэгжиж байна вэ. Тухайлбал, Азийн хөгжлийн банкны орон нутгийн хөгжлийг дэмжсэн төсөл бий юу?

-Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрт нэлээд анхаарч байна. Зөвхөн төсөвт найдах бус өөр боломж эрэлхийлнэ. Хамрагдсан албан ёсны төсөл, хөтөлбөр алга. Цаашид үүнийг бий болгохоор ажиллаж байгаа. [ЗГМ]

Алтны ханш хоёр сарын дээд цэгт хүрлээ



Алтны спот ханш сүүлийн нэг сард (ам.доллараар)

Шар металлын ханш дөрвөн өдөр дараалан өсөж. Ингэснээр олон улсын зах зээлд алтны ханш арваннэгдүгээр сараас хойших дээд цэгт хүрлээ. Унци алтны ханш 2000 ам.долларыг шүргэж байна. Олон улсын зах зээлд алтны спот ханш нүрвэ гаргт 0.7 хувиар өсөж, 1199 ам.доллартай тэнцлээ. Эсрэгээрээ ам.долларын ханш уруудав. Шар металтай

урвуу хамааралтай ам.долларын ханш уруудаж байна. АНУ-ын улс төрийн нөхцөл байдал ам.долларын ханшид дарамт болж байна. Голлох арван валюттай харьцах ам.долларын спот индекс 0.3 хувиар буурсан байна. Энэ нь өнгөрсөн сарын 14-нөөс хойших ёроолын цэг юм. Японы иентэй харьцах ам.долларын ханш 0.8 хувиар буурсан байна. [ЗГМ]

[Засгийн Газрын МЭДЭЭ]

ТАНАЙ КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ ЭНД БАЙРЛАЖ БОЛНО

99903584, 99903581

МОНГОЛД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ ГАДААД КОМПАНИУД

НЭР	СИМБОЛ	БИРЖ	ВАЛЮТ	ХАНШ	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
RIO TINTO	RIO	ASX	AUD	62.87	▲ +0.95%	1/12/2017
WOLF PETROLEUM	WOF	ASX	AUD	0.02	▼ -5%	1/12/2017
PETRO MATAD	MATD	LON	GBX	9.825	▲ +10.12%	1/12/2017
ASPIRE MINING	AKM	ASX	AUD	0.032	▼ -3.03%	1/12/2017
GUILDFORD COAL	GUF	ASX	AUD	0.013	▼ -7.69%	1/11/2017
PROPHECY DEVELOPMENT	PCY	TSX	CAD	4.72	▲ +2.16%	1/12/2017
TURKVOISE HILL RESOURCES	TRQ	TSX	CAD	4.56	▼ -2.98%	1/12/2017
SOUTHGOBI RESOURCES	SGQ	TSX	CAD	0.255	▼ -3.77%	1/11/2017
XANADU MINES	XAM	ASX	AUD	0.2	▼ -5%	1/12/2017
ENTREE GOLD	ETG	TSX	CAD	0.45	▲ +4.65%	1/12/2017

ТҮҮХИЙ ЭД

НЭР	СИМБОЛ	НЭГЖ	ХАНШ (\$)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
АЛТНЫ СПОТ	XAU	унци	1205.25	▲ +1.38%	1/12/2017
ЦАГААН АЛТ	PLA	унци	990.8	▲ +1.47%	1/12/2017
МӨНГӨ	SIA	унци	16.93	▲ +0.61%	1/12/2017
ЗЭС (COMEX)	HGA	фунт	262.3	▲ +0.48%	1/12/2017
ТӨМРИЙН ХҮДЭР	TIOA	тонн	79.14	▲ +0.62%	1/12/2017
WPT TOS	CLA	баррель	52.84	▲ +1.13%	1/12/2017
БРЕНТ	COA	баррель	55.82	▲ +1.31%	1/12/2017
БЕНЗИН	XBA		161.27	▲ +1.24%	1/12/2017
БАЙГАЛИЙН ХИЙ	NGA	Mmbtu	3.302	▲ +2.42%	1/12/2017
НҮҮРС (NYMEX)	QZA	тонн	333.55	▲ +0.36%	1/12/2017
НҮҮРС (NEW CASTLE)	XWA	тонн	82.2	▲ +1.29%	1/12/2017
ЭЛСЭН ЧИХЭР	SBA	фунт	0.207	▲ +0.78%	1/12/2017
БУДАА	RRA	центнер	9.63	▲ +0.21%	1/12/2017
БУУДАЙ	WA	бушель	416.75	▼ -0.48%	1/12/2017
КАКАО	CCA	тонн	2169	▼ -1.97%	1/12/2017
КОФЕ	KCA	фунт	1.501	▲ +0.74%	1/12/2017

Энэхүү ханшийн мэдээлэл нь хүснэгтэд заасан өдрийн 15 цагийн байдлаарх дүн тул үүнээс хойш өөрчлөгдсөн байх боломжтой.

Тэнцвэртэй мэдээллийг Танд

The New York Times

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

НЭР	СИМБОЛ	ХАНШ (нэгж)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
АПУ ХК	APU	370.64	▲ 0.17 %	1/12/2017
ГОВЬ ХК	GOV	10180	▼ -1.45 %	1/12/2017
МАХИМПЕКС ХК	MMX	2799	▲ 3.67 %	1/12/2017
СҮҮ ХК	SUU	128.16	▼ -0.42 %	1/12/2017
ТАЛХ ЧИХЭР ХК	TCK	19300	▲ 6.45 %	1/12/2017
АТАР ӨРГӨӨ ХК	ATR	62000	◄ 0.00 %	1/12/2017
МОГОЙН ГОЛ ХК	BDL	6200	▲ 8.77 %	1/12/2017
БАЯНГОЛ ХК	BNG	42000	◄ 0.00 %	1/12/2017
АРВИГ ГАЛ ХК	EER	2300	◄ 0.00 %	1/12/2017
ХӨХ ГАН ХК	HGN	66.73	▲ 1.12 %	1/12/2017
ЖЕНКО ТҮР БЮРО ХК	JTB	65.49	▼ -3.55 %	1/12/2017
МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК	MCH	603.87	▼ -13.61 %	1/12/2017
ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП ХК	MDR	450	◄ -0.00 %	1/12/2017
РЕМИКОН ХК	RMC	55	▼ -0.95 %	1/12/2017
ТАВАНГОЛГОЙ ХК	TTL	2650	▼ -1.08 %	1/12/2017

Тухайн өдөр арилжаалагдсан хувьцаа

ДЭЛХИЙН ГОЛЛОХ ИНДЕКСҮҮД

НЭР	СИМБОЛ	ХАНШ (нэгж)	ӨӨРЧЛӨЛТ	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
NASDAQ COMPOSITE	CCMP	5563.648	+11.83	▲ +0.21%	1/12/2017
DAX INDEX	DAX	11599.14	-47.03	▼ -0.4%	1/12/2017
TORONTO STOCK EXCHANGE	SPTSX	15491.54	+65.26	▲ +0.42%	1/12/2017
S&P/ASX 200	AS51	5766.855	-4.63	▼ -0.08%	1/12/2017
S&P 500	INX	2275.32	+6.42	▲ +0.28%	1/12/2017
SHANGHAI COMPOSITE	SHCOMP	3119.289	-17.47	▼ -0.56%	1/12/2017
DOW JONES INDUSTRIAL AVERAGE	INDU	19954.28	+98.75	▲ +0.5%	1/12/2017
TOP 20	MSETOP	12199.29	-34.07	▼ -0.28%	1/12/2017
FTSE 100	UKX	7282.44	-8.05	▼ -0.11%	1/12/2017
HANG SENG	HSI	22829.02	-106.33	▼ -0.46%	1/12/2017
NIKKEI 225	NKY	19134.7	-229.97	▼ -1.19%	1/12/2017